



SCAN ME



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Монгол Улс, Улаанбаатар хот 17011, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,
Махатма Гандигийн гудамж, МҮХАУТ-ын байр

☎ Утас: (+976) 77277070

☎ Факс: (+976) 11 324620

🌐 www.mongolchamber.mn

📘 [mongolchamber](https://www.facebook.com/mongolchamber)

✉ chamber@mongolchamber.mn

🐦 [mongol_chamber](https://twitter.com/mongol_chamber)



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ



2023

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Таны бизнесийн дүү хоолой

- МЭНДЧИЛГЭЭ
- ГИШҮҮНЧЛЭЛ
- НӨЛӨӨЛӨЛ
- БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ
- СУДАЛГАА
- ХАМТЫН АЖИЛЛАГАА
- АРГА ХЭМЖЭЭ
- ШАГНАЛ, ШАЛГАРУУЛАЛТ
- ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ
- ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР
- ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ
- СУРГАЛТ
- МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТР
- ТАНХИМЫН ДОТООДОД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ
- САЛБАР ТАНХИМ
- ХАВСРАЛТ

ЭРХЭМ ЗОРИЛГО



МҮХАҮТ нь бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлөгч, өмгөөлөгч, бизнесийн хөгжилд чиглүүлэгч, холбогч, дэмжигч байна.

АЛСЫН ХАРАА



МҮХАҮТ нь бизнесийн амжилтын ТАЛБАР байж, дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд манлайлахад ХӨТӨЧ нь болно.

ҮНЭТ ЗҮЙЛС



- ▶ Чадварлаг, эвсэг хамт олон
- ▶ Нягт, үр дүнтэй хамтын ажиллагаа
- ▶ Үнэ цэнтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ
- ▶ Ёс зүйт үйл ажиллагаа
- ▶ Манлайлал



СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД

ЕРӨНХИЙЛӨГЧ	ИЛ ТОД МАНЛАЙЛАЛ	Ил тод стратегийг ил тод манлайллаар хэрэгжүүлнэ
THINK TANK CLUB	БИЗНЕСИЙН ОРЧНЫ БОЛОН САЛБАРЫН БОДЛОГЫН ШИЙДЭЛ ГАРГАДАГ БОЛОХ	Бизнесийн орчны болон бодлогын шийдлийг тодорхойлох чадамжтай байх Бодлогод нөлөөлдөг байх
SME САНХҮҮЖИЛТ	САНХҮҮЖИЛТИЙН ШИЙДЭЛТЭЙ БАЙГУУЛЛАГА БОЛОХ	Санхүүжилтийн шийдэл Гадаад худалдаа, экспортыг дэмжих
ОРОЛЦООНД СУУРИЛСАН ШИЙДЭЛ / ГИШҮҮД /	ОЛОН НИЙТЭД НӨЛӨӨ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА БАЙЖ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН НЭР ХҮНДИЙГ ӨНДӨРТ ӨРГӨХ	Бүтцийн өөрчлөлт (Газарзүйд суурилсан → Үнэ цэнэд суурилсан) Гишүүн нэмэгдүүлэх (5.000 → 50.000)



МЭНДЧИЛГЭЭ

МҮХАҮТ-ын гишүүд, удирдах зөвлөл, тэргүүлэгч та бүхний амрыг эрье.

МҮХАҮТ нь ээлжит 21 дүгээр их хурлаа 2023 оны 9 дүгээр сард амжилттай зохион байгуулж, хурлаар 2019-2023 оны танхимын үйл ажиллагааг дүгнэн хэлэлцсэн бөгөөд Удирдах Зөвлөл, Ерөнхийлөгчийг сонгосон. Танхим өнгөрсөн жилүүдэд цар тахлын улмаас нийгэм эдийн засгийн маш том сорилт бэрхшээл үүссэн нөхцөлд үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, эдийн засаг бизнест учрах эрсдлийг бууруулах, хохирол багатай даван туулах гарц шийдлийг олж шийдвэрлүүлэхийн төлөө идэвх санаачилгатай, үр дүнтэй ажилласныг онцлон дурдах байна.

Сүүлийн 10 гаруй жилийн эдийн засгийн өсөлт, нэг хүнд оногдох ДНБ, татварын ачаалал болон төрийн өмчийн тоон үзүүлэлтүүдийг харьцуулан авч үзэхэд эдийн засаг дах төрийн оролцоо улам нэмэгдэж, төсөв ихээр тэлж, хувийн хэвшлийн татварын ачаалал нэмэгдсэн дүр зурагтай байна. Монголын бизнесийн орчны 2023 оны судалгаагаар бизнесийн орчин 2.68 гэж үнэлэгдсэн нь цар тахлын өмнөх үеэс буурсан үзүүлэлт бөгөөд бизнес эрхлэгчдийн зүгээс татварын таатай орчныг бүрдүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, бизнесийн зээлийн хүүг бууруулж нөхцөлийг сайжруулах, мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэх тогтолцоог шинэчлэх арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

МҮХАҮТ нь ирэх 4 жилд "Бизнесийн сэргэлт"-ийн төлөө төр засагтай санаачилгатай ил тод ажиллах, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, төр хувийн хэвшлийн түншлэлд үр ашигтай оролцоог хангах, аж ахуйн нэгж хоорондын хөрөнгө оруулалт ба худалдан авалтын хамтын ажиллагааг дэмжих, экспортын салбар бүрийн нэгдсэн бодлогыг гарган хэрэгжүүлэх, инновац ба бүтээмжийг нэмэгдүүлэх санаачилгуудыг дэмжих болон бизнесийн ёс зүй, нийгмийн хариуцлагыг сайжруулах гэсэн зорилтуудыг ханган ажиллах болно.

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бизнесийн төрийн бус байгууллагууд, мэргэжлийн холбоодод танилцуулж санал авсны үндсэн дээр шинэчлэн боловсруулж ХЗДХЯ-нд 2024 оны 1 дүгээр сард хүргүүлсэн бөгөөд энэхүү хуулийн шинэчлэл нь төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хэлэлцлийн үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх суурийг тавихад ач холбогдолтой гэж үзэж байна.

МҮХАҮТ-аас дэвшүүлж байгаа "Бизнесийн сэргэлт"-ийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бизнес эрхлэгчдийн санаачилга, нэгдмэл байдал, оролцоо чухал бөгөөд танхимын гишүүн байгууллагууд манлайлан оролцоно гэдэгт итгэл дүүрэн байна. Та бүхэнд амжилт, сайн сайхныг хүсье.



МЭНДЧИЛГЭЭ

МҮХАҮТ-ын үйл ажиллагааг дэмждэг гишүүд, бизнес эрхлэгчид Та бүхэнд юуны өмнө талархлаа илэрхийлье.

МҮХАҮТ нь худалдаа эдийн засгийн харилцааг хөгжүүлэх, эдийн засаг бизнесийн судалгааны цар хүрээг өргөжүүлэх, бизнес дэх хүний эрх ба бизнесийн ёс зүйн чиглэлээр төсөл хэрэгжүүлэх, ажил үйлчилгээгээ цахимжуулах чиглэлээр тодорхой үр дүн гарган ажиллалаа. Танхимын гишүүдийн тоо 2023 оны эцэст 5998 хүрсэн нь 2022 оноос 4.5 хувиар, 2019 оноос 38 хувиар өссөн байна.

Танхимаас 2023 онд бизнесийг дэмжих чиг үүргийн хүрээнд 40 гаруй томоохон хурал арга хэмжээ, B2B уулзалтуудыг зохион байгуулсан. Монгол, Орос, Хятадын ХАҮТ-уудын худалдаа, эдийн засгийн 16 дах удаагийн чуулганыг "Эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад ХАҮТ-уудын хамтын ажиллагаа ба түншлэл" сэдвийн хүрээнд 450 гаруй оролцогчтойгоор зохион байгуулсан нь цар тахлын дараах нөхцөл байдалд гурван улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд танхимууд хэрхэн хамтран ажиллах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлж, харилцан ойлголцлыг шинэ түвшинд гаргасан ач холбогдолтой арга хэмжээ болсон гэж үзэж байна.

Мөн гадаад дотоодод 9 үзэсгэлэнг зохион байгуулж, 12 үзэсгэлэнд бизнес групп оролцуулсан. Үүнд АНУ-ын Худалдааны яамны худалдааны арга хэмжээний түншлэлийн хөтөлбөрийн дэмжлэгээр Лас Вегас хотноо 3 жил тутам зохиогддог Барилга, уул уурхайн салбарын томоохон үзэсгэлэнд 20 гаруй төлөөлөгчийг оролцууллаа. "Улаанбаатар түншлэл" олон улсын үзэсгэлэн яармагт БНХАУ, ОХУ, Беларусь зэрэг улсаас 70 гаруй оролцогч оролцож, нийт 110 гаруй аж ахуйн нэгж бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулсан.

Олон улсын Худалдааны Төв (ITC)-өөс 2023 оны 7 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан "Дэлхийн экспортыг дэмжих форум"-ын хувийн

хэвшлийн B2B уулзалтыг танхим хариуцан хийсэн бөгөөд эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих SheTrades төслийн салбарыг МҮХАҮТ-ын дэргэд байгууллаа. SheTrades Hub нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд үүлэн технологиор дамжуулан үйл ажиллагаагаа өргөжүүлэх, ашиг орлого нэмэгдүүлэх, туршлага солилцох, дэлхийн худалдааны зах зээлд оролцох боломжуудыг олгох ач холбогдолтой юм. Мөн Европын Холбооноос хөрөнгө оруулалтыг татах, нэмүү өртөг шингэсэн шууд экспортын гарцыг өргөжүүлэх зорилгоор 2023 оны 5 дугаар сард Монгол улсын Худалдааны танхимыг Брюссель хотноо нээсэн.


"Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем"-д танхимаас олгодог гарал үүслийн гэрчилгээг холбох программыг хөгжүүлж, ашиглаж эхэлсэн. Мөн гарал үүслийн гэрчилгээний одоогийн системийг сайжруулан, гаалийн автоматжуулсан мэдээллийн систем (CAIS)-тэй холбож, АХБ-ны "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл" (RIBS)-ийн хүрээнд санал болгож буй Үндэсний нэг цонх (NSW)-ны системд модуль болгох төслийн эхний шатыг хэрэгжүүлээд байна.

Үндэсний сатистикийн хороотой хамтран "Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдал сэдэвчилсэн судалгаа"-г хийж тайланг гаргасан. Монголын бизнесийн орчин 3 жил тутмын судалгааг Улаанбаатар хот, нийслэлийн 4600 гаруй аж ахуйн нэгжийг оролцуулан явуулж, үр дүнг 2023 оны 12 дугаар сард олон нийтэд танилцууллаа.

"Executive summit" арга хэмжээг 2023 оны 2 дугаар сард "Өөрчлөлтөөр манлайлъя" уриан дор 3 дах жилдээ зохион байгуулсан ба түүнчлэн гүйцэтгэх захирлуудын суурь чадамжийг хөгжүүлэх, манлайллын ухааны хамгийн сүүлийн үеийн мэдлэг, ойлголтыг богино хугацаанд өгөх "Seo update" хөтөлбөрийг санаачилж сургалтыг эхлүүлсэн. "Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх" төслийг танхимын дэргэдэх "Бизнесийн ёс зүйн төв" дээр амжилттай хэрэгжүүллээ.

МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирал
Т.ДҮҮРЭН

МҮХАҮТ-ЫН БҮТЭЦ






ГИШҮҮНЧЛЭЛ

МҮХАҮТ нь үндэсний хэмжээнд аж ахуй нэгжүүдийг эгнээндээ нэгтгэн гишүүнчлэлийнхээ цар хүрээг өргөжүүлсээр байна.

2023 онд нийт гишүүдийн тоо 5998 болж өссөнөөс Улаанбаатар хотын гишүүн байгууллагын тоо 2609 болж өмнөх оноос 227-оор нэмэгдэж нийт гишүүдийн тоо өмнөх оноос 4,5 хувиар нэмэгдсэн байна.



◆ ГИШҮҮДИЙН ТОО




● Улаанбаатар ● Салбар танхим ● Нийт гишүүд

◆ 2023 ОНД НЭМЭГДСЭН НИЙТ ГИШҮҮДИЙН ТОО



◆ УЛААНБААТАР ХОТЫН ГИШҮҮДИЙН АНГИЛЛЫН ТОО





НӨЛӨӨЛӨЛ

Бизнесийн хууль эрх зүйн орчныг сайжруулахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хууль эрх зүй, бодлогын баримт бичиг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг, хороод зөвлөл дэх танхимын оролцоог сайжруулах, Засгийн газар, яамд болон төрийн бусад байгууллагуудтай тогтвортой үр дүнтэй хамтран ажиллахад анхаарч ажилласан.

◆ **БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХАД ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА**

Монгол Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдтай бизнесийн орчныг сайжруулах, хууль эрх зүйг боловсронгуй болгох, эдийн засгийн гол салбаруудыг дэмжих чиглэлээр 2023 онд уулзалтууд хийсэн нь бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохих үр дүнгээ үзүүлсэн.

МҮХАҮТ ба ХЗДХЯ хооронд хамтын ажиллагааг өргөжүүлэх, бизнес эрхлэх хууль, эрх зүйн таатай орчныг бий болгоход төр, хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоог хөгжүүлэх зорилготой санамж бичгийг 2023 оны 2 дугаар сард байгуулсан бөгөөд санамж бичгийн дагуу хуулийн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, саналуудыг нэгтгэн хүргүүлэн, хамтран ажиллаж байна. Мөн арилжааны хуулийн төсөл боловсруулах, компанийн тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсгүүдэд танхимын төлөөлөл болон танхимын дэргэдэх Хуулийн бодлогын зөвлөлийн гишүүдээс орж ажиллаж байна.

2023 оны 10 дугаар сард МҮХАҮТ-ын ерөнхийлөгч Д.Энхтүвшин болон Хуулийн



бодлогын зөвлөлийн төлөөллүүд Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяртай уулзалт хийж цаашид хамтран ажиллах чиглэл, арга хэмжээний талаар ярилцаж тогтсон.

Ажлын хэсэг, зөвлөл, хороодод ажилласан байдал:


Бизнес, хувийн хэвшлийг төлөөлөн нийт 78 ажлын хэсэг, зөвлөл хороодод орж ажилласнаас ерөнхийлөгч 25, гүйцэтгэх захирал 17, бусад удирдлага газар нэгжийн дарга нар 28, танхимын дэргэдэх зөвлөлөөс 12 ажлын хэсэг, хороодод ажилласан байна. МҮХАҮТ-ын төлөөллийн хувьд ажлын хэсгийн хуралд тогтмол оролцох, санал бодлоо илэрхийлэх, тухайн асуудлаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, гарсан саналыг нэгтгэн, зөвлөмж хүргүүлэх зэргээр ажилласан.

◆ **БОДЛОГЫН ЗӨВЛӨЛҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ХУУЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

Хуулийн бодлогын зөвлөлөөс “Өглөөний зочин” уулзалтыг тогтмол зохион байгуулж, Арилжааны хуулийн хэрэгцээ, шаардлага, ШӨХТГ-аас гарч буй шийдвэр арга хэмжээ, Фидикийн гэрээ, Хууль тогтоомжийн системчлэл сэдвүүдээр хийсэн.

Зөвлөлөөс санаачлан “Бизнесийн орчин ба арилжааны хуулийн хэрэгцээ, шаардлага” сэдэвт хэлэлцүүлгийг ХЗДХЯ-тай 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан бөгөөд хуульчид болон бизнес эрхлэгчдийн 100 гаруй төлөөлөл оролцсон. Уг хэлэлцүүлгээр “Арилжааны тухай хуулийн төсөл”-ийг танилцуулан хуулийн төслийг боловсруулах үндэслэл шаардлага, үзэл баримтлал болон зарим орны туршлагын талаар санал солилцож, бизнес эрхлэгчдээс хуулийн төсөлд тусгах саналын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.



НООС НООЛУУРЫН ЗӨВЛӨЛ



ОХУ-ын Эрхүү мужийн амбан захирагч И.И.Кобзевийн 2023 оны 3 дугаар сард Монгол Улсад хийсэн албан айлчлалын хүрээнд Ханбогд кашимер ХХК-ийн үйлдвэртэй танилцуулсан.

2023 оны 5 дугаар сард “Түүхий эд бэлтгэл ба гурван талын оролцоо, хамтын ажиллагаа” сэдвээр ноолуурын эртэц цуврал уулзалтыг хийсэн.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ



2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр “Монгол-Тайванийн аялал жуулчлалын бизнесийн боломж” уулзалтыг хамтран зохион байгуулсан. Мөн “Экспортын үндэсний стратеги”-ийг боловсруулахад дэмжлэг үзүүлж буй Олон улсын худалдааны төвийн төлөөлөлтэй салбарын уулзалтыг хийж зөвлөлийн гишүүд санал бодлоо илэрхийлсэн.

Аялал жуулчлал, зочлох үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, салбарын ажиллах хүчний чадавхыг сайжруулах, шинэлэг мэдээ, мэдээллээр хангах зорилгоор Бизнес академитай хамтран 2023 оны 10 дугаар сард “Бизнесийг эрчимжүүлэх менежментийн хөтөлбөр” сургалтыг зохион байгуулж, гэрчилгээ олгосон.



ХУДАЛДААНЫ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдаж гарах хуулийн төслүүдэд зөвлөлийн гишүүн Джей Ти Ай Казахстан ХХН-н Монгол дахь төлөөлөгчийн газар, Сентрал Экспресс Си Ви Эс ХК ба Дижитал концепц ХХК-аас ирүүлсэн саналуудыг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд уламжилсан. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг нэгтгэн УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очирт хүргүүлсэн.

Монгол Улсаас Канад улсад суугаа ЭСЯ болон Канад Монголын Худалдааны Танхимтай хамтран “Монгол-Канадын бизнес форум”-ыг зохион байгуулахад оролцсон.

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН НЭГДСЭН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн төлөөлөл болон ЗТХЯ-ны төлөөлөл оролцсон уулзалтыг хийж, МҮХАҮТ-ын дэргэд шинээр Монгол-Орос-Хятадын зөвлөл байгуулах, Монгол улсын дэд бүтцийн төслүүдийг танилцуулах дотоод ба гадаад арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулахаар тогтсон. Энэхүү уулзалтаар ярилцсаны дагуу 2023 оны 6 дугаар сард Монгол, Хятад, Орос ХАҮТ-уудын 3 талт чуулга уулзалтын хүрээнд “Монгол, Хятад, Оросын чөлөөт бүсүүдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж, гарц, шийдэл” чуулга уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Мөн зөвлөлийн дарга Ч.Амарбаатар илтгэл танилцуулж, панелистаар оролцсон.

Зөвлөлийн дарга Ч.Амарбаатар тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод ажил хэргийн айлчлал хийсэн.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод зохион байгуулагдсан Монгол - Хятадын 4 дүгээр экспод зөвлөлийн гишүүд оролцсон.



ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ЗӨВЛӨЛ

2023 оны 6 дугаар сарын 10-ны өдөр "Шинэ сэргэлтийн бодлого" Зам, тээврийн сэргэлт, Зам тээврийн салбарын хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг зохион байгуулахад зөвлөлийн гишүүд идэвхтэй оролцсон.

Японы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Зам тээврийн, хөгжлийн яамтай хамтран "Монгол Улсын тээвэр логистикийн чиг хандлага" семинарыг 2023 оны 10 дугаар сард зохион байгуулсан.

Монгол Улс болон БНХАУ-ын "Засгийн газар хоорондын олон улсын шинжлэх ухаан, технологи, инновацийн хамтын ажиллагаа"-ны хүрээнд хийгдэх Хятад, Монголын хил дамнасан логистикийн нэгдсэн ухаалаг үйлчилгээ төслийг БНХАУ-ын Гуанжоу хотын судалгааны хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлэхээр судалгааны ажлыг эхлүүлээд байна.



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРУУДЫН ЗӨВЛӨЛ

Олон улсын лабораторийн өдрийг тохиолдуулан 2023 оны 4 дүгээр сард олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулж буй Гаалийн төв лабораторитой танилцах, туршлага судлах аяллыг зохион байгуулсан. Аялалд нийт 40 гаруй лабораторын төлөөлөл оролцсон.



2023 оны 4 дүгээр сард зохион байгуулагдсан НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр болон ДБХС-ийн Ази тивд био аюулгүй хэрэглээг ОУ-ын хамтын ажиллагааны хүрээнд дэмжих нь төсөл үндэсний хэмжээний чуулга уулзалтанд зөвлөлийн гишүүд оролцсон.

Үндэсний чанарын чуулганыг 2023 оны 11 дүгээр сард зохион байгуулсан ба "Итгэмжлэгдсэн лабораториудын хүртээмжтэй байдал" сэдэвт салбар хуралдааныг зөвлөлөөс зохион байгуулсан.

ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлд туссан болон МҮХАҮТ-ын удирдлагаас өгсөн саналуудыг тусган хуулийн төслийг 2023 оны 1 дүгээр сард шинэчлэн гаргасан.

Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт даалгасан бөгөөд 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаар ХАҮТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон.

ХАҮТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ХЗДХЯ-ны ажлын хэсгийн 2023 оны 11 дүгээр сарын хурал дээр хуулийн төслийн талаар хэлэлцээд МҮХАҮТ-ын эрх үүрэг, ажил үйлчилгээ болон зарим асуудлаар МҮХАҮТ дээр ярилцаж, томъёолохоор тогтсон бөгөөд энэ дагуу МҮХАҮТ-ын удирдлага, хуульч, арбитраас бүрдсэн дотоод ажлын хэсэг байгуулан ажилласан.




МҮХАҮТ-ын дотоод ажлын хэсгээс нэмэлт мэдээлэл, тоо баримтыг боловсруулсан бөгөөд хуулийн төслийг МҮХАҮТ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн санал авч, мөн Удирдах зөвлөл, 21 аймгийн ХАҮТ, 20 гаруй мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагуудад төслийг хүргүүлсэн. Хуулийн төсөлд 7 байгууллагаас санал ирүүлснийг тусган хуулийн шинэчилсэн төслийг боловсруулж 2024 оны 1 дүгээр сард ХЗДХЯ-д хүргүүлсэн.



БОДЛОГЫН ӨМГӨӨЛӨЛ

МҮХАҮТ 2023 онд 23 хууль, журам, бодлогын баримт бичигт санал өгч, 18 санал зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан ба 30 гаруй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ



САНАЛ ӨГСӨН БУСАД ГОЛ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

- ◆ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл болон түүнийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд санал боловсруулан УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлсэн.
- ◆ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөлд санал боловсруулан УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн.
- ◆ Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлтэй танилцаж УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороонд санал боловсруулан хүргүүлсэн.
- ◆ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал боловсруулан УИХ-ын ЭЗБХ-нд хүргүүлсэн.
- ◆ Мэргэжлийн техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд УИХ-ын БСШУСБХ-нд санал боловсруулан хүргүүлсэн.
- ◆ Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал боловсруулан ХНХЯ-нд хүргүүлсэн.
- ◆ Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал боловсруулан УИХ-ын ЭЗБХ-нд хүргүүлсэн.

БОДЛОГЫН САНАЛ ЗӨВЛӨМЖ



- ◆ “Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн уул уурхайн бус экспортлогчидтой хийх өглөөний уулзалтаас гарсан саналуудыг нэгтгэн ЭЗХЯ болон Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлсэн.
- ◆ ЭЗХЯ-тай хамтран “Уул уурхайн бус экспорт”-ын зөвлөгөөнийг зохион байгуулан, уг зөвлөгөөнд оролцсон уул уурхайн бус экспортлогчдын саналыг нэгтгэн ЭЗХЯ-нд хүргүүлсэн.
- ◆ Монгол Улсын Их Хурлын даргын ажлын албатай хамтран зохион байгуулсан “Татварын цогц шинэчлэл” хэлэлцүүлэгт оролцогчдын саналыг нэгтгэн УИХ-ын Дарга, ЗГХЭГ болон Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн.
- ◆ Монгол Улсын засгийн газар, хувийн хэвшлийн ээлжит зөвлөлдөх уулзалтаас гарсан саналуудад үндэслэн МУЗГ, МҮХАҮТ хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан ЗГХЭГ болон ЭЗХЯ-нд хүргүүлсэн.
- ◆ НӨАТ-тай холбоотой асуудлаар бизнес эрхлэгчдийн санал болон Бизнесийн орчны судалгааны НӨАТ-тай холбогдох үр дүнг нэгтгэн УИХ-ын дарга Г.Занданшатарт хүргүүлсэн.
- ◆ Бизнес эрхлэгчдэд тулгарч буй хүндрэл, эрх зүйн орчны ойлгомжгүй байдал, оновчгүй зохицуулалтын талаар аж ахуйн нэгжүүдээс санал авч, мөн өмнөх зохион байгуулсан уулзалт хэлэлцүүлгүүдээс гарсан саналыг нэгтгэн томъёолж ЗГХЭГ-т хүргүүлсэн.
- ◆ Засгийн газрын 2022 оны 362 дугаар тогтоол хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Катодын зэс экспортлогч ААН-үүдэд тулгарч буй асуудлын талаар саналыг Сангийн сайд, ГЕГ, Гаалийн төв лабораторид хүргүүлсэн.
- ◆ Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн Монгол талын төлөвлөлтийн төсөлд санал хүргүүлсэн.

УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, АРГА ХЭМЖЭЭ



ТАТВАРЫН ЦОГЦ ШИНЭЧЛЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Уг хэлэлцүүлэгт МҮХАҮТ-ын удирдлагууд, УИХ-ын дарга, УИХ-ын гишүүд, судлаачид болон бизнесийн 90 гаруй төлөөлөл оролцож, Монгол улсын татварын орчны өнөөгийн байдал, татвартай холбоотой асуудлуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ"-ИЙН УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТЛОГЧИДТОЙ ХИЙХ ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ

Уулзалтад ЭЗХЯ-ны сайд Ч.Хүрэлбаатар, ХХААХҮ-ийн сайд Х.Болорчулуун болон хүнсний бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолуур, арьс шир, гоо сайхан, эм, эмийн бүтээгдэхүүн, мэдээллийн технологи, банк бус санхүүгийн байгууллага, судалгаа, маркетингийн салбарын төлөөлөл оролцсон.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭЭЛЖИТ ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ

Монгол Улсын Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй зөвлөлдөх уулзалтыг хийсэн. Уг уулзалтад МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Д.Энхтүвшин Монголын бизнесийн орчны судалгааны үр дүнгийн талаар танилцуулж, татварын таатай орчин буюу хүртээмжтэй байдал болон хүний нөөцийн хомсдол зэрэг асуудлуудыг нэн тэргүүнд анхаарах шаардлагатайг онцолсон.



ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ХУВИЙН ХЭВШЛИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ НЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хэлэлцүүлэгт бизнесийн салбарын 90 гаруй төлөөлөл оролцон татварын орчин, мөнгөний ханш, гадаадын хөрөнгө оруулалтын орчин, хил гаалийн чөлөөт хэлэлцээрийн асуудал, тээвэр логистик, хүний нөөцийн хомсдол зэрэг асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлэх, мөн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хуулийг яаралтай батлах талаар саналуудыг дурдсан.



САНХҮҮЖИЛТ ТАТАХ БОЛОМЖ-ТОГТВОРТОЙ САНХҮҮ БОЛОН НОГООН БОНД ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд тогтвортой санхүүжилт, ногоон бондын ач холбогдол, тэдгээрийн зохицуулалтын орчны талаар мэдээлэл өгөх, аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилт татах боломж, дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн талаар танилцуулж, санал солилцох зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Олон улсын санхүүгийн корпорац, Монголын тогтвортой санхүүжилтийн холбоотой хамтран зохион байгуулсан.



◆ БУСАД ТОМООХОН УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

- ◆ Экспортыг дэмжих, эдийн засгийг тогтворжуулах боломж, шийдэл хэлэлцүүлэг /2023 оны 2 сарын 10/
- ◆ "Бизнесийн ёс зүй, сайн засаглал, зөв менежментийн тогтолцоо" дугуй ширээний уулзалт /2023 оны 2 сарын 16/
- ◆ Хөдөлмөрийн хууль тогтоомжийн шинэчилсэн зохицуулалтын үр нөлөө хэлэлцүүлэг /2023 оны 4 сарын 11/
- ◆ ЗТХЯ-тай хамтран "Шинэ сэргэлтийн бодлого:Зам, тээврийн сэргэлт Зам тээврийн салбарын хөрөнгө оруулалтын чуулга уулзалт /2023 оны 6 сарын 9/
- ◆ "Ёс зүйтэй бизнес, тогтвортой өсөлт" хэлэлцүүлэг /2023 оны 8 сарын 22
- ◆ Монгол улсын тээвэр логистикийн чиг хандлага хэлэлцүүлэг /2023 оны 10 сарын 20/
- ◆ Захиргааны хэм хэмжээний актын хуульд нийцсэн байдал, хоорондын уялдаа, давхардал, зөрчлийг арилгах асуудлаар хэлэлцүүлэг /2023 оны 11 сарын 23/
- ◆ "Бизнесийн орчин ба арилжааны хуулийн хэрэгцээ, шаардлага" хэлэлцүүлэг /2023 оны 12 сарын 14/
- ◆ Аялал жуулчлалын үндэсний хороо болон Ерөнхий сайдын ажлын албатай хамтран Монгол Улсыг сурталчлах түлхүүр үгийг танилцуулах арга хэмжээ /2023 оны 12 сарын 30/




СУДАЛГАА

МҮХАҮТ нь бизнесийн орчны өнөөгийн байдал, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн үнэлгээ болон орчныг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг тодорхойлж уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төрийн болон ТББ-ын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөгөөт болон цаг үеийн шинжтэй гол 16 судалгаа, шинжилгээний ажил хийж гүйцэтгэв.

◆ МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЛОГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ СЭДЭВЧИЛСЭН СУДАЛГАА

МҮХАҮТ-аас "Монгол Улсын экспортлогч аж ахуйн нэгжүүдийн сэдэвчилсэн судалгаа"-г ҮСХ-той хамтран явуулсан ба экспортлогч аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамруулсан анхны судалгаа болсноороо онцлог байв. Судалгааны үр дүнг танилцуулах уулзалт, хэвлэлийн бага хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, үр дүнгийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэн олон нийт, төрийн байгууллагууд, олон улсын байгууллагуудад танилцуулав.



ГОЛ ҮР ДҮН

- ◆ Монгол Улсад экспортод бүтээгдэхүүн үйлчилгээ гаргадаг 1923 аж ахуйн нэгж байгаа ба эдгээрийн 77.1 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг, 81 орчим хувь нь 2.5 тэрбум төгрөгөөс бага борлуулалтын орлоготой бичил, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид байна.
- ◆ Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн дунджаар 90 орчим хувь нь экспорт хийхтэй холбоотой санхүүжилтийн эх үүсвэрийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэж байгаа нь энэ төрлийн бизнес эрхлэгчдэд тохирсон зорилтот санхүүжилтийн дэмжлэг дутмаг, санхүүгийн хэрэгцээ өндөр, хангалттай өсөн дэвшиж чадахгүй байгааг харуулж байна.
- ◆ Экспортлогч аж ахуйн нэгжүүдийн 16.5 хувь (улсын дүнгээс 2 дахин өндөр) нь хэрэглэгч үйлчлүүлэгчдэдээ чиглэсэн бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийсэн, цаашид авлига, хүнд суртлыг бууруулах нь экспортыг хөгжүүлэхэд чухал дэмжлэг болно гэж үзэж байна.


◆ МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ОРЧИН-2023 СУДАЛГАА



Судалгааг МҮХАҮТ, МУИС хамтран 3 жил бүр явуулдаг бөгөөд бизнесийн орчны нөхцөл байдлыг 300 орчим нарийвчилсан үзүүлэлтүүдээр, үндэсний хэмжээнд аж ахуйн нэгжүүдийг хамруулан судалдаг хамгийн том бизнесийн орчны судалгаа юм. 2023 оны судалгааг 4-12 сарын хугацаанд явуулж, Улаанбаатар хот орон нутгийн нийт 4606 аж ахуйн нэгжийг хамруулсан.

Монголын бизнесийн орчин-2023 судалгаа нь цар тахлын өмнөх болон дараах үеийн бизнесийн орчны нөхцөл байдал, өөрчлөлтийг харьцуулах, цаашид хямралын дараах сэргэлт, өсөлтийн үе шатуудад аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, эдийн засаг бизнесийн салбараа өргөжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, шаардагдах дэмжлэгийг оновчтой тодорхойлох ач холбогдолтой.

БИЗНЕСИЙН ОРЧНЫ ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ



ГОЛ ҮР ДҮН

- ◆ Бизнес эрхлэгчид 2023 оны бизнесийн орчинд 2.68 гэсэн үнэлгээ өгсөн ба үнэлгээг цар тахлын өмнөх 2020 онтой харьцуулбал 0.23 нэгжээр буурсан байна. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэгчид цар тахлын өмнөх үетэй харьцуулахад бизнесийн орчин муудсан гэж үзсэн.
- ◆ Ерөнхий 5 орчны үнэлгээнээс төрийн байгууллагын засаглал хууль эрх зүйн орчинтой холбогдох үзүүлэлт 2.40 ба хамгийн бага үнэлгээтэй байна. Цаашид төрийн үйл үйл ажиллагааг сайжруулахад дүрэм журмыг тодорхой болгох, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах, хүнд суртлыг бууруулах шаардлагатай байна.

- ◆ Цар тахлын нөлөөгөөр бизнесийнхэн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах зорилгоор төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь бизнесийн дотоод үйл ажиллагааг сайжруулахад эергээр нөлөөлсөн ба 2020 оноос сайжирсан ганц үнэлгээ нь бизнесийн байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлт байна.
- ◆ Бизнес эрхлэх орчныг сайжруулахад санхүүжилтийн эх үүсвэр, зээлийн олдоц нөхцөлийг сайжруулах, татварын таатай орчин бүрдүүлэх, бизнестэй холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулан, тогтвортой ойлгомжтой байх зэрэг нь хамгийн чухал байна гэжээ.

◆ БУСАД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛУУД



- ◆ МҮХАҮТ-ын сэтгэл ханамжийн судалгаа
- ◆ Цар тахлын дараах иргэдийн орлогын судалгаа
- ◆ 2022 оны Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгжийн эрэмбэ
- ◆ Ургамлын аргаар идээлүүлсэн сарлагийн арьс шир ба арьсан бүтээгдэхүүний кластерийн гишүүдийн хэрэгцээ шаардлагын үнэлгээ судалгаа (SWITCH ASIA тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд)
- ◆ Бизнесийн итгэлийн индекс судалгаа (2022-2023 он)
- ◆ МҮХАҮТ-ын XXI Их хурлын үед Монгол улсын захирлуудын цаг үеийн санал асуулга
- ◆ Идэр есийг давах төлөвлөгөөний асуумж
- ◆ Эрдэнэс Монгол ХХК-ийн ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтын шалгалтын үр дүнд хийсэн статистик шинжилгээ
- ◆ НӨАТ-ыг 5 хувь болгосноор эдийн засаг, бизнест үзүүлэх нөлөөллийн шинжилгээ
- ◆ Монгол улсын цалин, ажлын хөлсний өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ
- ◆ ТББ, мэргэжлийн болон бизнесийн холбоодын тоон шинжилгээ, тойм зураг (Танхимын хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэг)
- ◆ Гадаад улс орнуудын гадаад худалдааны шинжилгээ
- ◆ Монгол улсын эдийн засгийн тойм (жил, улирлаар)
- ◆ 2024 оны Монгол улсын нэгдсэн төсвийн төслийн тойм

ХАМТЫН АЖИЛЛАГАА

МҮХАҮТ нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, холбох зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, төрөл бүрийн арга хэмжээ хамтран зохион байгуулах зорилгоор дотоодод нийт 12 газар, гадаад орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, хоёр талын бизнес эрхлэгчдийг холбох зорилгоор 21 байгууллагатай тус тус санамж бичиг байгуулан хамтран ажилласан.

◆ ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ

Хууль зүй дотоод хэргийн яам	International Trade Centre (Олон улсын худалдааны төв)	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Ур Чадвар Үйлдвэрлэлийн Холбоо	Барилгын ханган нийлүүлэгчдийн зөвлөл ТББ	Голомт банк
Цахим хөгжил, харилцаа холбооны яам	Монгол улсын их сургууль	Замын Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба
Богд Банк	JCI Прогресс салбар байгууллага	
Санхүүгийн зохицуулах хороо		

◆ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ



Кувейтийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ы Худалдааг дэмжих хороо	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Нонбан технологийн компани
Оросын Холбооны Улсын Дорнод Сибирийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрээн хотын Худалдааг дэмжих хороо	"Москвагийн бизнес эрхлэгчдийн ассоциаци" Бүс хоорондын олон нийтийн байгууллага
Оросын Холбооны Улсын Эрхүү мужийн Хөгжлийн корпораци	Хятад-Азийн эдийн засгийн хөгжлийн ассосацийн уул уурхайн мэргэжлийн хороо	Хакасийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
Польшийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	Оросын Холбооны Улсын Эрхүү мужийн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх корпораци	Бүгд Найрамдах Буриад Улсын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
Польшийн Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлаг		

БНСУ-ын Жэжугийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

Красноярскийн хязгаарын "Төв Сибирийн Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим"

Янтай хотын Үйлдвэрлэл худалдааны худалдааны холбоо

БНХАУ-ын Shandong Lanqiao Group Co.,LTD

Бүгд Найрамдах Франц Улсын Олон улсын аж ахуй нэгжүүдийн хөдөлгөөн /MEDEF/

Бүгд найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Худалдаа аж Үйлдвэрийн Танхим

БНХАУ-ын Tungshu Group

БНХАУ-ын Олон улсын худалдааг дэмжих хорооны Бугат хотын хороо

◆ ГАДААД ОРНУУДАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТОМООХОН АРГА ХЭМЖЭЭ, УУЛЗАЛТУУД

ТУРКИЙН АРД ТҮМЭНД ТУСЛАХ ХАНДИВЫН АЯН



Бүгд Найрамдах Турк Улсын ард иргэдэд хүнд гарз тохиолдсонд эмгэнэл илэрхийлж МҮХАҮТ нь гишүүн байгууллагууддаа уриалга гарган, хандив цуглуулан Туркийн элчин сайдын яаманд хүлээлгэн өгсөн. Хандивт МҮХАҮТ-аас гадна 26 байгууллагын нийт 49 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн, мөнгөн хандивыг Элчин сайдад гардуулан өгсөн.




МОНГОЛ-АВСТРИЙН БИЗНЕС ФОРУМ



МҮХАҮТ-аас Австрийн эдийн засгийн танхим (WKO), Монгол улсаас Австри Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран Монгол-Австрийн бизнес форумыг 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан.

Бизнес форумд Монгол Улсаас нийт 6 аж ахуйн нэгжийн 11 төлөөлөгч оролцсон бол Австрийн талаас 30 гаруй аж ахуйн нэгж оролцож хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар мэдээлэл солилцож, эрдэс баялаг, цахим боловсрол,



эрүүл мэнд, хүнсний хангамж болон аюулгүй байдлыг сайжруулах, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, байгаль орчинд ээлтэй, ухаалаг хотыг хөгжүүлэхэд хамтран ажиллах боломжийн талаар ажил хэрэгч хэлэлцүүлэг өрнүүлсэн.

БРЮССЕЛЬ ДАХЬ МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДААНЫ ТАНХИМ



Монгол Улсаас Европын холбоонд гаргах экспортын бараа бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг олшруулах, Европын Холбооноос Монгол Улсад хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, "ченжийн бус", нэмүү өртөг шингэсэн шууд экспортын гарцыг өргөжүүлэх зорилгоор 2023 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Брюссель дахь Монгол Улсын Худалдааны танхим буюу МҮХАҮТ-ын Европ дахь салбар Танхимыг нээсэн.

Брюссель дахь Монгол Улсын Худалдааны Танхим нь Монгол Улсаас Европын холбоонд гаргах экспортын бараа бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг олшруулах, Европын Холбооноос Монгол Улсад хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, "Ченжийн бус", нэмүү өртөг шингэсэн шууд экспортын гарцыг өргөжүүлэх зэргээр ажиллах юм.



ДЭЛХИЙН ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ФОРУМ



Олон улсын Худалдааны Төв (ITC)-өөс жил бүр зохион байгуулдаг "Дэлхийн Экспортыг Дэмжих Форум"-ыг Монгол Улсад зохион байгуулахад Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллаж хувийн хэвшлийн B2B уулзалтыг хариуцан зохион байгуулж, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих SheTrades төслийн Монгол Улс дах салбарыг МҮХАҮТ-ын дэргэд байгуулсан.

"МОНГОЛ-ХЯТАДЫН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА" ФОРУМ



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн БНХАУ-д хийж буй албан ёсны айлчлалын хүрээнд МҮХАҮТ, БНХАУ-ын Олон улсын худалдааг дэмжих хороо (ОУХДХ) хамтран "Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа" форумыг Бээжин хотноо 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан.

Монголын талаас уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, эрчим хүч, тээвэр логистик, аялал жуулчлал, ноос ноолуур, банк санхүү зэрэг салбарын нийт 90 гаруй компанийн 130 гаруй төлөөлөгч, Хятадын талаас 350 орчим бизнес эрхлэгч оролцсон.

Форумаар цаашид худалдааг төрөлжүүлэх, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай гэдгийг тодотгосон ба нийт 2,2 тэрбум ам.долларын мөнгөн дүн бүхий хамтын ажиллагааны 25 гэрээг үзэглэсэн юм.



МОНГОЛ-ФРАНЦЫН БИЗНЕС ФОРУМ



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Франц Улсад хийж буй төрийн айлчлалын хүрээнд МҮХАҮТ, Монгол Улсын Гадаад харилцааны яам, Парис хот дахь Монгол Улсын Элчин сайдын яам, БНФУ-ын Аж ахуйн нэгжүүдийн хөдөлгөөн, Франц Монголын бизнес зөвлөл хамтран Монгол-Францын бизнес форумыг 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Парис хотноо амжилттай зохион байгуулсан.



Тус форумын үеэр МҮХАҮТ, Францын Аж ахуйн нэгжүүдийн хөдөлгөөний олон улсын байгууллага хооронд байгуулсан санамж бичгээ шинэчлэн үзэглэсэн юм.

МОНГОЛ-ВЬЕТНАМЫН БИЗНЕС ФОРУМ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын хүрээнд Гадаад харилцааны яам, Монгол Улсаас Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсад суугаа Элчин сайдын яам, МҮХАҮТ, БНСВУ-ын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим хамтран зохион байгуулсан тус форумд Монгол улсаас 70 гаруй, Вьетнамын талаас 80 гаруй, нийт 200 орчим төлөөлөгч оролцсон.

МОНГОЛ-ЛАОСЫН БИЗНЕС ФОРУМ



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад хийж байгаа төрийн айлчлалын хүрээнд "Монгол-Лаосын бизнес форум"-ыг 2023 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр тус улсын нийслэл Вьентьян хотноо амжилттай зохион байгуулсан.

Мөн бизнес форумын үеэр МҮХАҮТ, ЛУХАҮТ-ын хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг хоёр талын танхимуудын Ерөнхийлөгчид үзэглэв.

Форумын үеэр хоёр улсын бизнес эрхлэгчдийн дунд В2В уулзалт болон Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүний танилцуулах үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан.



◆ БУСАД УУЛЗАЛТУУД:



- ◆ БНХАУ-ын Эрээн хотын захиргааны төлөөлөлтэй худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх тухай уулзалт /2023 оны 2 сарын 12/
- ◆ БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод Экспортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж компанийн төлөөллүүд хилийн худалдааны бүс болон Эрээн хотын олон улсын хурал, үзэсгэлэнгийн төвтэй танилцав /2023 оны 2 сарын 13/
- ◆ Монгол-Солонгосын бизнес форум /2023 оны 2 сарын 14/
- ◆ Катар-Монголын бизнес форум /2023 оны 3 сарын 6/

- ◆ Кувейт–Монголын бизнес форум /2023 оны 3 сарын 8/
- ◆ Австри-Монголын бизнес уулзалт /2023 оны 3 сарын 21/
- ◆ Люксембургийн Худалдааны Танхимын Олон улсын асуудал эрхэлсэн захирал Синди Тереба-тай хамтран ажиллах уулзалт /2023 оны 4 сарын 6/
- ◆ Бүх Хятадын Худалдааг Дэмжих Хорооны орлогч дарга Жан Шао Гантай хамтын ажиллагааны санал солилцох уулзалт /2023 оны 5 сарын 11/
- ◆ “БҮС БА ЗАМ” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний III чуулга уулзалт /2023 оны 10 сарын 17/
- ◆ ОУХТ-ын дэргэдэх эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих SheTrades Hub-уудын нэгдсэн уулзалт /2023.11.15/
- ◆ Олон улсын худалдааны танхимуудын худалдаа, хөрөнгө оруулалтын IX чуулган /2023 оны 11 сарын 15/

◆ ДОТООДОД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТОМООХОН АРГА ХЭМЖЭЭ, УУЛЗАЛТУУД

МОНГОЛ, ОРОС, ХЯТАДЫН ХАҮТ-УУДЫН ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН XVI ЧУУЛГАН



“Эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад ХАҮТ-уудын хамтын ажиллагаа ба түншлэл” сэдвийн хүрээнд Монгол, Орос, Хятадын ХАҮТ-уудын Худалдаа, эдийн засгийн XVI чуулганыг Улаанбаатар хотноо 2023 оны 6 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд зохион байгуулсан.



Ковид-19 цар тахлын дараах шинэ нөхцөл байдалд гурван улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд Танхимууд хэрхэн хамтран ажиллах, цаашид авч хамтран хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлж харилцан ойлголцлыг шинэ түвшинд гаргасан онцгой ач холбогдолтой арга хэмжээ болсон.



◆ Монгол, Хятад, Оросын Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимуудын худалдаа, эдийн засгийн XVI чуулганы тунхаг бичигт талууд гарын үсэг зурж баталгаажуулсан.

- ◆ Бизнесийн томоохон төслүүдийг хөрөнгө оруулагчдад сурталчлах, бизнес хөрөнгө оруулалтыг дэмжих хоёр ба гурван талт уулзалт арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулах
- ◆ ОХУ, БНХАУ, Монгол Улсын нутаг дэвсгэрт зохион байгуулагддаг эдийн засаг, хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүний дотор ерөнхий болон салбарын онцлогтой олон улсын үзэсгэлэн, конгресс зэрэгт аж ахуйн нэгжүүдийг оролцуулахад дэмжлэг үзүүлэх
- ◆ Баруун, зүүн босоо тэнхлэгийн авто зам ба төмөр зам, хуурай, усан, хилийн боомт, эрчим хүч зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн хамтарсан хөрөнгө оруулалтыг дэмжин ажиллах
- ◆ Гурван улсын эдийн засгийн коридорын хөтөлбөрт тусгасан төслүүдэд болон эдийн засгийн коридорын дагуух чөлөөт бүсүүдэд хөрөнгө оруулах, үйл ажиллагаа явуулахад нь хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдэд тал бүрийн дэмжлэг үзүүлэх
- ◆ Монгол Улсын газарзүйн байршлын онцлогт тулгуурлан олон улсын транзит тээврийг хөгжүүлэхэд хамтран ажиллах
- ◆ Гурван улсын худалдаан дахь тарифын болон тарифын бус саад тотгор, хязгаарлалтыг багасгах, худалдааг хөнгөвчлөх, чөлөөтэй болгох зэрэг асуудлаар хамтран ажиллах
- ◆ Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүнийг ОХУ, БНХАУ-ын зах зээлд экспортлох, гуравдагч оронд экспортлоход ОХУ, БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх үеийн хяналт, шалгалт, хорио цээрийн шаардлагын асуудлыг шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- ◆ Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд шинэ маршрут гаргах, бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах
- ◆ Худалдааг дэмжих олон улсын ба бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох
- ◆ Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлд аж ахуйн нэгжүүдийг дэмжих, харилцан туршлагаа солилцох, сайн туршлагыг түгээх



МОНГОЛ-ЯПОНЫ БИЗНЕС ФОРУМ /2023.8.18/



Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), МҮХАҮТ, Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төв хамтран зохион байгуулсан “Монгол-Японы бизнес форум-2023”-д Японы 100 гаруй, Монголын 400 гаруй төлөөлөгч оролцсон.

Форумын үеэр Япон, Монголын экспортыг хөгжүүлэхэд чиглэсэн дэмжлэг, Мэдээлэл, харилцаа холбоо, цахим технологи, уур амьсгалын өөрчлөлт, нээлттэй инноваци зэрэг сэдвээр танилцуулга хийж, хэлэлцүүлэг өрнүүлсэн.



НҮБ-ын Даян Дэлхийн Гэрээнд хэрхэн нэгдэн орох тухай уулзалт /2023 оны 5 сарын 23/

Польш-Монголын бизнес форум /2023 оны 4 сарын 25/

ОХУ-аас МУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Алексей Николаевич Евсиковтой хамтын ажиллагаагаа өргөжүүлэх уулзалт /2023 оны 6 сарын 1/

Монгол Улс, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны төслийн танилцуулга уулзалт /2023 оны 6 сарын 23/

Австри-Монголын бизнес форум /2023 оны 9 сарын 15/

Монгол, Тайваний 19 дэх удаагийн уулзалт /2023 оны 9 сарын 26/

Аж ахуйн нэгжүүдийн ханган нийлүүлэлт, худалдаа, эдийн засаг хөрөнгө оруулалтын бизнес уулзалт /2023 оны 9 сар 26/

МҮХАҮТ-ын дэргэдэх Эрчим Хүчний Зөвлөл болон БНХАУ-ын Бугат хотын олон улсын худалдааг дэмжих хорооны хамтарсан уулзалт /2023 оны 9 сарын 28/

Монгол-Беларусийн бизнес уулзалт /2023 оны 10 сарын 3/

ОХУ, Монгол улс хоорондын экспортын боломжийн талаар уулзалт /2023 оны 10 сарын 17/

Монгол улс, ОХУ-ын эрхүү мужийн бизнес эрхлэгчдийн B2B уулзалт /2023 оны 10 сарын 26/

Монгол-Чехийн бизнес форум /2023 оны 10 сарын 31/

ХБНГУ-ААС Монгол Улсад суугаа бүрэн эрхт элчин сайд Хэльмут Кулитцтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх санал солилцох уулзалт /2023 оны 11 сарын 10/

Бүгд Найрамдах Узбекистан Улсаас Монгол Улсад хавсран суух элчин сайд ноён Фарход Арзиевтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх санал солилцох уулзалт /2023 оны 11 сарын 15/

Бүгд Найрамдах Куба Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд ноён Хорхе Альберто Феррер Родригестой хамтын ажиллагааг өргөжүүлэх санал солилцох уулзалт /2023 оны 11 сарын 17/

Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин Сайд ноён Жашим Уддинтай хамтран ажиллах, санал солилцох уулзалт /2023 оны 11 сарын 17/

Бүгд Найрамдах Серби Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин Сайд эрхэмсэг хатагтай Маяа Стефановичтой хамтын ажиллагааг өргөжүүлэх санал солилцох уулзалт /2023 оны 11 сарын 21/

Арабын Бүгд Найрамдах Сири Улсаас Монгол Улсад хавсран суух Элчин Сайд Ноён Хасанеин Хаддамтай хамтын ажиллагааг өргөжүүлэх уулзалт /2023 оны 11 сарын 21/

Монгол-ОХУ-ын бизнес эрхлэгчдийн B2B уулзалт /2023 оны 11 сарын 30/

◆ БУСАД ФОРУМ, УУЛЗАЛТУУД

Монгол-Оросын бизнес форум /2023 оны 3 сарын 24/

Монгол-Унгарын бизнес форум /2023 оны 3 сарын 24/

Бүгд Найрамдах Польш Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Кшыштоф Бойкогтой хамтран ажиллах уулзалт /2023 оны 3 сарын 27/

Бүгд Найрамдах Латви Улсаас МУ-дсуугаа Онц бөгөөд Бүрэн эрхт сайд Майя Маникагтай бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх уулзалт /2023 оны 3 сарын 30/

Израил Улсаас МУ-д хавсран суух Онц Бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ирит Бен-Абба Виталетай хамтран ажиллах санал солилцох уулзалт /2023 оны 3 сарын 31/

Монгол-Угандагийн бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх уулзалт /2023 оны 3 сарын 31/

Бүгд Найрамдах Эстони Улсаас Монгол Улсад хавсран суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт сайд Ханнес Хансогтой хамтран ажиллах уулзалт /2023 оны 4 сарын 5/

Эстони Улсын Цахим Засаглалын Академийн зөвлөлтэй санал солилцох уулзалт/2023 оны 4 сарын 7/

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын БНХАУ, Монгол Улсыг хариуцсан хөдөлмөрийн товчооны захирал Чангхи Литай хамтран ажиллах уулзалт /2023 оны 4 сарын 10/

Монгол-Унгарын бизнес уулзалт – цахим уулзалт /2023 оны 4 сарын 20/

Манжуур хотын үзэсгэлэн, бизнес уулзалт /2023 оны 4 сарын 21/





АРГА ХЭМЖЭЭ

EXECUTIVE SUMMIT 2023

Executive Summit 2023 гүйцэтгэх дээд удирдлагуудын уулзалт-хэлэлцүүлэг “ӨӨРЧЛӨЛТӨӨР МАНЛАЙЛЪЯ” уриан дор гурав дахь жилдээ зохион байгуулагдсан. Нээлтийн арга хэмжээнд МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч О.Амартүвшин оролцож, арга хэмжээний үндсэн илтгэлийг хэлэлцүүлсэн.

МҮХАҮТ-аас бизнесийн салбарын өмнө тулгамдаж байгаа сорилтуудын шийдлийг эрэлхийлж “EXECUTIVE SUMMIT 2023” Гүйцэтгэх удирдлагын дээд уулзалтыг “Lead by change” уриан дор зохион байгуулсан.



Энэхүү арга хэмжээнд Монголын бизнес эрхлэгчдийн шинэ залуу үеийн төлөөлөл болсон 150 гаруй захирал, гүйцэтгэх удирдлага оролцсон бөгөөд Тогтвортой хөгжилд баримжаалсан, ёс зүйтэй, сайн засаглалтай компанийг ХАМТЫН МАНЛАЙЛАЛД түшиглэн хөгжүүлэхээр нэгдсэн.

“СТАНДАРТ БА ХӨГЖИЛ”

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН НЭГДСЭН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

МҮХАҮТ нь стандарт, чанарын асуудлыг эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, аж ахуй нэгжүүдийг дэмжих талаас нь илүү анхаарч ажилладаг. Энэ хүрээнд хууль эрх зүйн орчныг сайжруулах, аж ахуйн нэгжүүдэд олон улсын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээнд тавигддаг олон улсын чанарын стандартын шаардлагыг таниулах чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ, сургалтуудыг зохион байгуулж ирсэн. Эдгээрийн нэг нь СХЗГ-тай хамтран жил бүр зохион байгуулдаг Үндэсний чанарын өдрийн арга хэмжээ болон Үндэсний чанарын шагналын шалгаруулалт юм.



“Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн нэгдсэн хэлэлцүүлгийн нээлтийн үеэр 2022 оны Үндэсний чанарын шагналыг гардуулсан.

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ ЭРХ ЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦОХ НЬ СЭДЭВТ УУЛЗАЛТ, ЗӨВЛӨГӨӨН

МҮХАҮТ, Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ)-тай хамтран тус газраас үзүүлж буй үйлчилгээ, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын эрх зүйн орчин, хөрөнгө оруулагч, жуулчны виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл, цахим визийн www.evisa.mn системийн танилцуулга хийж, хувийн хэвшлийн төлөөлөлтэй санал солилцох, бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудлыг тодорхойлох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хамтарсан санал, дүгнэлт гаргах уулзалтыг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан.

Уулзалт, зөвлөгөөнд Америкийн Нэгдсэн Улсын ЭСЯ, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын ЭСЯ, БНХАУ-аас Монгол Улсад хөрөнгө оруулагчдын Зунхуа нийгэмлэг, МҮХАҮТ-ын дэргэдэх Аялал жуулчлалын зөвлөл, уул уурхай, барилга тоног төхөөрөмж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын нийт 90 гаруй төлөөлөгч оролцов.



БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ, КОМПАЕНСЫН ҮНДЭСНИЙ II ФОРУМ

МҮХАҮТ, Рио Тинто Монгол компани, Транспэрэнси Интернэшнл ТББ хамтран хэрэгжүүлж буй “Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх” төслийн хүрээнд “Бизнесийн ёс зүйн төв” болон МҮХАҮТ-ын дэргэдэх Компаенсын зөвлөлөөс “Бизнесийн ёс зүй, Компаенсын Үндэсний II форум”-г зохион байгууллаа.



МҮХАҮТ-ын дэргэдэх Комплаенсын зөвлөлийн зөвлөх, гишүүд болон бизнес эрхлэгчдийн төлөөлөл 150 гаруй оролцогч танхимаар, орон нутгийн бизнес эрхлэгчид цахимаар оролцсон.

Ёс зүй ба шударга өрсөлдөөн, Хөдөлмөрийн харилцаа, Комплаенсыг хэрэгжүүлэхийн ач холбогдол болон сорилт бэрхшээлийн талаар панел хэлэлцүүлгүүдийг өрнүүлж, бизнесийн ёс зүйг баримтлах хэрэгцээ шаардлага, ёс зүйг баримталснаар урт хугацаанд тогтвортой хөгжих болон бизнесийн ашиг орлогоо нэмэгдүүлэх боломж, ач холбогдлын талаар хэлэлцэж, санал солилцсон.

◆ ИМПОРТЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН СТАНДАРТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол Улсын шадар сайд С.Амарсайханы Шадар сайдын ажлын алба болон Барилга хот байгуулалтын яам, Гаалийн ерөнхий газар, Стандарт хэмжил зүйн газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Барилгын хөгжлийн төв, Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар, МҮХАҮТ, Барилгын ханган нийлүүлэгчдийн зөвлөл хамтран Импортын барилгын материалын стандарт хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан.



◆ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН АСУУДЛААР БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН БАЙР СУУРЬ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хувийг нэмэгдүүлэх замаар өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтөөс үүдэн иргэдэд ирж буй үнийн дарамтыг бууруулах, нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн тоог нэмэгдүүлэх, далд эдийн засгийг бууруулахад олон нийтээс авсан санал дээр бизнес эрхлэгчдийн байр суурийг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэхээр санал бодлоо солилцсон.



◆ МҮХАҮТ-ЫН XXI ИХ ХУРАЛ

МҮХАҮТ-ын XXI их хурал 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж, Ерөнхийлөгчөөр Д.Энхтүвшин сонгогдсон. Түүнчлэн, Удирдах зөвлөл анхны хуралдаанаа 2023 оны 9 дүгээр 21-ний өдөр хийж, МҮХАҮТ-ын Гүйцэтгэх захирлаар Т.Дүүрэнг улираан сонгосон.

Мөн хурлаар танхимын 25 Тэргүүлэгч гишүүдийг сонгосон бөгөөд Тэргүүлэгчид нь МҮХАҮТ-ын дүрэмд зааснаар Удирдах Зөвлөлийн хурал хооронд МҮХАҮТ-ын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй.



МҮХАҮТ-ын Ерөнхийлөгчөөр 2019-2023 онд ажилласан О.Амартүвшин тамга, тэмдгээ 2023 оны 9 дүгээр 22-ны өдөр шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Д.Энхтүвшинд хүлээлгэн өгсөн.

◆ “СТАНДАРТ БА ХӨГЖИЛ” ЧАНАРЫН ЧУУЛГАН

МҮХАҮТ нь стандарт, чанарын асуудлыг эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, аж ахуй нэгжүүдийг дэмжих талаас нь илүү анхаарч ажилладаг. Энэ хүрээнд хууль эрх зүйн орчныг сайжруулах, аж ахуйн нэгжүүдэд олон улсын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээнд тавигддаг олон улсын чанарын стандартын шаардлагыг таниулах чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээ, сургалтуудыг зохион байгуулж ирсэн. Эдгээрийн нэг нь СХЗГ-тай хамтран жил бүр зохион байгуулдаг Үндэсний чанарын өдрийн арга хэмжээ болон Үндэсний чанарын шагналын шалгаруулалт юм.

“Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн нэгдсэн хэлэлцүүлгийн нээлтийн үеэр 2022 оны Үндэсний чанарын шагналыг гардуулсан.



◆ “SHETRADES MONGOLIA HUB BEYOND YOUR BORDER”



Дэлхийн 30 орны 3 сая эмэгтэй бизнес эрхлэгчдийг нэгтгэсэн бизнесийн томоохон networking платформ болох Олон улсын худалдааны төвийн дэргэдэх эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих “SheTrades Hub” төвийн Монгол Улс дахь салбарыг 2023 оны 6 дугаар сард албан ёсоор нээсэн.



МҮХАҮТ, Азийн сан, Голомт банк, МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес Ёс Зүйн Төв хамтран “SheTrades Mongolia Hub Beyond Your Border” арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.



◆ “ЦАХИМ ЭДИЙН ЗАСАГ ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРАХ ХӨШҮҮРЭГ БОЛОХ НЬ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ЭЗХЯ, МҮХАҮТ, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран зохион байгуулж Монгол улсын экспорт сүүлийн 20 жилийн хугацаанд төрөлжөөгүй, нэг төрлийн бүтээгдэхүүнээс хамааралтай. Энэ нь дэлхийн зах зээл дэх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурсан жилүүдэд ДНБ-ний хэмжээ буурч, үнэ өсөх үед ДНБ-ний хэмжээ нэмэгддэг тогтворгүй өсөлтийг бий болгоод байна. Иймд цахим эдийн засгийн шилжилтэд тулгуурлан эдийн засгийг төрөлжүүлэх, гадаад худалдааны нээлттэй байдлыг нэмэгдүүлж, экспортын боломжийг өргөтгөхөд хувийн хэвшилд тулгамдаж буй асуудлыг шийдэх зорилгоор төр, хувийн хэвшлийн төлөөлүүд санал солилцов.





ШАГНАЛ, ШАЛГАРУУЛАЛТ

◆ LADY ENTREPRENEUR 2023 АРГА ХЭМЖЭЭ



МҮХАҮТ, Бизнес академи, Азийн сан, Бизнесийн ёс зүйн төв, Рио Тинто хамтран "LADY ENTREPRENEUR" ёслолын үйл ажиллагааг "Бизнес дэх эмэгтэйчүүдийн манлайлал" сэдвийн хүрээнд шинэ өнгө төрх, шинэлэг хэлбэрээр зохион байгуулсан. Арга хэмжээнд нийт 200 гаруй бизнес эрхлэгч эмэгтэй оролцож, "Бизнес дэх эмэгтэйчүүдийн манлайлал - Women leadership in Business-SheTrades Hub", "Хүчирхэг дуу хоолой - Strengthening your voice", "Зоригтой манлайлал - Dare to lead", "Нетворкингд өөрийгөө амжилттай хоногшуулах-Succesfully express yourself at Networking",

"Асралын эдийн засаг - Care economy", Ёс зүйтэй манлайлал, "Асралын эдийн засаг"-ийн талаар хэлэлцүүлэг өрнүүлсэн.



Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй үндэсний томоохон ТӨП-100 ААН-үүдийн хөрөнгийн зах зээл дэх идэвх оролцоог өсгөх замаар зах зээлийн хөгжлийг хурдасгаж, эдийн засагт гүйцэтгэх үр нөлөөг нэмэгдүүлэх, санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр МҮХАҮТ, Санхүүгийн зохицуулах хороо хамтран ажиллаж байгаа бөгөөд ТӨП-100 ААН-ийн Хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

◆ ҮНДЭСНИЙ ЧАНАРЫН ШАГНАЛ-2023



Стандарт Хэмжил Зүйн Газар, МҮХАҮТ хамтран "Үндэсний чанарын чуулган" нэгдсэн арга хэмжээг 9 дэх жилдээ "Стандарт ба хөгжил" сэдвийн хүрээнд зохион байгуулан "Үндэсний чанарын шагнал-2023" шагналыг гардуулсан юм.

◆ ENTREPRENEUR-2023

МҮХАҮТ-аас уламжлал болгон зохион байгуулдаг "Оны Шилдэг болон тодорхой салбарын Онцлох аж ахуйн нэгж"-ийг өргөмжлөн алдаршуулдаг "ENTREPRENEUR" шагнал гардуулах ёслол хүндэтгэлийн арга хэмжээ, Бизнес эрхлэгчдийн цэнгүүнийг 26 дахь жилдээ



◆ МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨП-100 АЖ АХУЙН НЭГЖ



Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ жил бүр хамтран ТӨП-100 ААН-ийг эрэмбэлэн, алдаршуулдаг хүндэтгэлийн үйл ажиллагааг 22 дахь жилдээ зохион байгуулсан.

ТӨП-100 ААН-ийн эрэмбийг тооцоходоо 51 ба түүнээс дээш хувь нь хувийн өмчит аж ахуйн нэгжүүдийн мэдээлэлд үндэслэн эрэмбэлсэн бөгөөд 91 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 9 нь хувьцаат компани байна. Аж ахуйн нэгжүүд олон нийтэд хувьцаагаа арилжин нээлттэй компани болсноор борлуулалтын орлого, ажиллагсдын тоо нь өссөн зэрэг эерэг дүн үзүүлсэн.

◆ **2022 ОНЫ ШИЛДЭГ АЖ АХУЙ НЭГЖҮҮДИЙН ТУГИЙГ МАНДУУЛЛАА**



МҮХАУТ-аас жил бүр уламжлал болгон шалгаруулдаг “Оны онцлох 10 аж ахуйн нэгж”-ээр шалгарсан шилдэг аж ахуйн нэгжийн туг өргөх ёслолын ажиллагааг 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан.

◆ **МҮХАУТ-ын нэрэмжит шагнал**

МҮХАУТ-аас Монгол Улсын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, хөгжлийг хурдасгах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, бичил, дунд бизнес болон ногоон эдийн засаг, ногоон бизнес, компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх, хувийн хэвшлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулж буй гадаад, дотоодын 50 байгууллага, аж ахуйн нэгж, 700 гаруй бизнес эрхлэгчийг өөрийн нэрэмжит дараах нэр бүхий шагналуудаар шагнаж урамшууллаа.



11

Business excellence award



121

Хийморь одон



21

Silk road



28

Entrepreneurship spirit



42

Шилдэг залуу бизнесмен



5

Greenpreneur



358

Хүндэт жуух



131


Хүндэт өргөмжлөл

ҮЗЭСГЭЛЭН ЯАРМАГ

ДОТООД ҮЗЭСГЭЛЭН



◆ **ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНОЛОГИ-2023**



МҮХАУТ нь Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газартай хамтран 25 дахь удаагийн “Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи” олон улсын үзэсгэлэнг Мишээл экспод 2023 оны 6 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд зохион байгуулав.

Энэ удаагийн үзэсгэлэнд нийслэл орон нутгийн нийт 100 гаруй жижиг дунд ААН, хувиараа бизнес эрхлэгч, үүн дотор хөдөө орон нутгаас Дархан, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудаас оролцлоо.

◆ **УЛААНБААТАР ТҮНШЛЭЛ-2023**



МҮХАУТ, НЗДТГ, Нийслэлийн бизнес инновац хөгжлийн газар хамтран 48 дахь жилдээ Улаанбаатар Түншлэл-2023 үзэсгэлэнг зохион байгуулсан.

Үзэсгэлэнд Бүгд Найрамдах Беларусь улс, Оросын Холбооны Улсаас 40 гаруй, БНХАУ-ын Ляонинь мужийн 30 гаруй бизнес эрхлэгч, дотоодын томоохон 40 гаруй ААН-үүд оролцож, Монголын зах зээлд өөрсдийн бараа бүтээгдэхүүнийг

танилцуулж харилцан хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулж, түншийн харилцаа тогтоосон.

Үзэсгэлэнд гадаадын орноос ХАА-н техник тоног төхөөрөмж, барилга, хүнс, хөнгөн үйлдвэр, эрүүл мэндийн салбар чиглэл болон, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээр оролцсон. Нийт 4 өдрийн турш 10,000 үзэгч ирж сонирхож 100 гаруй гэрээ хэлцэл, 3 санамж бичиг хийсэн үр дүнтэй боллоо.



ГАДААД ҮЗЭСГЭЛЭН



◆ CON EXPO ҮЗЭСГЭЛЭН

АНУ-ын Невада мужийн Лас Вегас хотод 3 жил тутамд 1 удаа АНУ-ын Худалдааны яамны Худалдааны арга хэмжээний түншлэлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулагддаг "Барилга, Уул уурхайн үзэсгэлэн" нь 2023 оны 3-р сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, МҮХАУТ-ын нийт 15 гишүүн байгууллагын 20 гаруй төлөөлөгчид уг үзэсгэлэнтэй танилцаж, оролцсон.



◆ МОНГОЛ-ХЯТАДЫН IV ЭКСПО



"Монгол-Хятадын Экспо" дөрөв дэх удаагаа БНХАУ-ын ӨМӨЗО-ы Хөх хотноо зохион байгуулагдлаа. Хоёр улсын "Иж бүрэн стратегийн түншлэл"-ийн хүрээнд эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2015 оноос эхлэн тус арга хэмжээ хоёр жил тутамд зохион байгуулагдаж ирсэн юм. Энэ удаа цар тахлын дараа "Хөгжлийн шинэ хэв маягийг бий болгож, хөгжлийн шинэ боломжийг хуваалцъя" сэдвийн хүрээнд 2023 оны 9 дүгээр сарын 6-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.



Уг экспо Хөх хотын "Цэлгэр тал" үзэсгэлэнгийн хотхонд зохион байгуулагдаж, Монгол-Хятадын худалдааны дөрөвдүгээр экспод 35 улсын төлөөлөл болон БНХАУ-ын 27 мужийн нийт 3000 гаруй аж ахуйн нэгж оролцож, бараа, бүтээгдэхүүнээ сурталчлан танилцуулсан юм.

◆ ХЯТАДЫН ОЛОН УЛСЫН ИМПОРТЫН VI ЭКСПО



БНХАУ-ын Худалдааны яам, Шанхай хотын Ардын Засгийн газар хамтран 6 дахь удаагийн "Хятадын Олон Улсын Импортын экспо"-г 2023 оны 11 дүгээр сарын 5-10-ны өдрүүдэд БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдан оролцлоо.

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газар, МҮХАУТ ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж, Олон улсын дүр төрхийн хэсэгт Монгол Улс 136м2 талбайд ноос ноолуур болон хүнсний бүтээгдэхүүнийг танилцуулан сурталчилсан.

Тус экспо нь 6 дах удаагаа болж байгаа бөгөөд Монгол улсын хувьд 2 дах удаагаа оролцож, уул уурхайн бус экспортын бараа болох ноос ноолуур, хүнс, шингэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийг сурталчлан таниулах зорилготой оролцсон юм.





ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

МҮХАҮТ нь олон улсын хэд хэдэн санхүүжүүлэгч байгууллагуудтай урт хугацааны туршид хамтран ажиллаж байна. Донор байгууллагуудынхаа хөрөнгө оруулалтын үр дүнд бид ажлын байрыг нэмэгдүүлэх, уул уурхайн бус бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, чадавхыг бэхжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг салбар бүрт хэрэгжүүлсээр байна.

◆ “БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ, ШУДАРГА БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ



Төслийн нэр:	Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх
Төслийн санхүүжүүлэгч:	“Рио Тинто Монгол” ХХК
Төсөл хэрэгжүүлэгч:	МҮХАҮТ, Бизнесийн Ёс зүйн төв
Нийт хугацаа:	2 жил
Төсөл эхэлсэн огноо:	2021.05
Төсөл дуусах огноо:	2023.12

МҮХАҮТ нь “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ, “Рио Тинто Монгол” ХХК-тай хамтран “Бизнесийн ёс зүй, шударга байдлыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн хүрээнд 2021 онд МҮХАҮТ-ын дэргэд “Бизнесийн ёс зүйн төв”-ийг байгуулан ажиллаж байна.

Зорилго: Бизнесийн Ёс Зүйн Төв” нь төслийн хүрээнд 2023 онд бизнесийн байгууллагуудад ёс зүйн дүрэм боловсруулах, хянах, туслалцаа үзүүлэх, Засаглалын тогтолцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх, Бизнесийн болон мэргэжлийн ёс зүй, шударга байдлын сургалтыг зохион байгуулах, холбогдох хэвлэмэл материал, мэдээллийг боловсруулах, эмхэтгэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

СУРГАЛТ: Хариуцлагатай бизнес, шударга байдлын аргачлал хэвшүүлэх нь сэдэвт сургалтыг нийт 24 удаа зохион байгуулсан бөгөөд 242 компанийн 424 оролцогч хамрагдсан байна.

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ: Нийт 20 гаруй компанид бодлогын баримт бичиг, ёс зүйн дүрэм, комплаенсын журам боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.

ЦАХИМ НОМЫН САН: Цахим номын санг тогтмол хөгжүүлэн ажиллаж Бизнесийн ёс зүй, комплаенс чиглэлийн 100 гаруй ном, гарын авлагыг байршуулсан байна.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ:

- НҮБ-Даян Дэлхийн Гэрээ
- Голомт Банк

◆ БУСАД ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЗЭСГЭЛЭНГҮҮД

Ногоон өдрүүд-2023 үзэсгэлэн

2023 оны 1 сарын 20-29
ХБНГУ, Берлин хот

Агро экспо-2023 үзэсгэлэн

2023 оны 2 сарын 1-5
БНТУ, Измир хот

Монгол-Оросын олон улсын үзэсгэлэн

2023 оны 2 сарын 8-12
ОХУ, Улаан-Үд хот

FOODEX-2023 үзэсгэлэн

2023 оны 3 сарын 7-10
Япон улс, Токио хот

Эмнэлэг, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үзэсгэлэн

2023 оны 3 сарын 23-26
БНСУ, Сөүл хот

Ухаалаг хот-2023 үзэсгэлэн

2023 оны 3 сарын 28 - 4 сарын 1
Тайван улс, Тайбэй хот

Хоккайдо 2023 Байгаль орчин, мэдээлэл технологийн үзэсгэлэн

2023 оны 4 сарын 15-18
Япон улс, Саппоро хот

“CPNI Japan” эм, эмийн орц найрлага, эрүүл мэндийн тоног төхөөрөмжийн үзэсгэлэн

2023 оны 4 сарын 19-21
Япон улс, Токио хот

Майами экспорт - импорт олон улсын үзэсгэлэн

2023 оны 7 сарын 11-13
АНУ, Флорида муж, Майами хот

14 дэхь удаагийн Хятад-Зүүн хойд Азийн Экспо

2023 оны 8 сарын 23-27
БНХАУ, Жилинь муж, Чанчунь хот

Монгол-Оросын-Хятадын 3-н талт чуулга уулзалт, үзэсгэлэн

2023 оны 8 сарын 30 – 9

сарын 3 / БНХАУ, ӨМӨЗО, Эрээн хот

Bazaar Berlin олон улсын үзэсгэлэн

2023 оны 11 сарын 8-21
ХБНГУ, Берлин хот

35 дахь удаагийн Тайваний барилгын үзэсгэлэн

2023 оны 12 сарын 7-10
Тайвань, Тайпей хот

Вэнжоу Импортын 5-р үзэсгэлэн

Хугацаа: 2023 оны 12 сарын 8-11 / БНХАУ, Вэнжоу хот

Шинэ жил үзэсгэлэн худалдаа

Хугацаа: 2023 оны 12 сарын 20-24 / ОХУ, БНБУ, Улаан-Үд хот

◆ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЗЭСГЭЛЭНГҮҮД

“Амар байна уу” Цагаан сарын үзэсгэлэн

2023 оны 1 сарын 20-оос 2-р сарын 20
Нийслэлийн ЖДҮҮДТ НӨҮГ

Эх оронч худалдан авалт, үндэсний үйлдвэрлэл-2023” үзэсгэлэн

2023 оны 3 сарын 3
Улаанбаатар хот, МҮХАҮТ

Намрын ногоон өдрүүд 2023 оны 9 сарын 20-26 ХХААХҮЯ

“International Distributors in Mongolia 2023” олон улсын үзэсгэлэн

2023 оны 11 сарын 16-19
Мишээл экспо ХХК

◆ **SWITCH ASIA "САРЛАГИЙН АРЬСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ" ТӨСӨЛ**



Төслийн нэр:	Монголын сарлагийн ширний кластерыг чадавхжуулах
Төслийн санхүүжүүлэгч:	Европын холбоо
Төсөл хэрэгжүүлэгч:	МҮХАҮТ
Нийт хугацаа:	4 жил
Төсөл эхэлсэн огноо:	2021.12
Төсөл дуусах огноо:	2025.12

"Монгол Улсад ургамлын аргаар идээлүүлсэн Сарлагийн арьсан бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих, чадавхыг бэхжүүлэх" төслийг хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын уулзалт зохион байгуулагдсан. Уг төсөл нь Европын холбооны санхүүжилттэй, Свитч Азия (SWITCH-Asia) тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байна.

Энэхүү төсөл нь 2025 он хүртэл хэрэгжих бөгөөд төслийн зорилго нь ургамлын идээлэгтэй сарлагийн арьсан бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, үйлдвэрлэх, эцсийн боловсруулалт хийх технологийг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх юм.

СУРГАЛТ

- ◆ 2023 оны 4 дүгээр сарын 24-28-ний өдрүүдэд арьс шир боловсруулах шинэ технологи танилцуулах онол, практик хослуулсан 4 өдрийн сургалт;
- ◆ 2023 оны 6 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд "Бараа бүтээгдэхүүний эко-шошго, худалдаа маркетинг, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, үндэсний болон олон улсын хэмжээнд мөрдөж буй хууль эрх зүйн шаардлагууд" сэдэвт сургалт
- ◆ 2023 оны 12 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд "Бүтээгдэхүүн, хог хаягдлыг дахин боловсруулахад хязгаарлаж буй материалын хэрэглээг арилгах зорилгоор өөр боловсруулалтыг ашиглах" сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулав.

ГАРЫН АВЛАГА "Арьсан бүтээгдэхүүнийг Европын Холбооны улсад экспортлох нь" экспортын гарын авлага

АРГА ХЭМЖЭЭ "Сарлагийн арьсан бүтээгдэхүүний тогтвортой үйлдвэрлэл" төслийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 22-28-ны өдрүүдэд Грек улсад зохион байгуулагдсан туршлага судлах сургалт, уулзалт болон төслийн удирдах хорооны хурлыг зохион байгуулсан.

◆ **"ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ" ТӨСӨЛ**



Төслийн нэр:	Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх
Төслийн санхүүжүүлэгч:	Азийн сан
Төсөл хэрэгжүүлэгч:	МҮХАҮТ, Бизнес Академи
Нийт хугацаа:	1 жил
Төсөл эхэлсэн огноо:	2022.10.12
Төсөл дуусах огноо:	2023.10.12

Азийн сангийн "Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх" төсөл нь Монгол Улсын эдийн засагт эмэгтэйчүүдийн оролцоо болоод манлайллыг дээшлүүлэх зорилготой. Энэхүү "Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх" төслийг 2023 оны 10 сарын 12-нд амжилттай хэрэгжүүлж дууссан.

ҮР ДҮН

- ◆ **2,000** гаруй бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг хувь хүний хөгжлийн болон бизнесийн хөгжлийн сургалтад хамруулсан.
- ◆ **494** хүн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.
- ◆ **1,134** эмэгтэйг холбоо харилцаа тогтоох уулзалт, форум, үзэсгэлэн яармаг болон бусад үйл ажиллагаанд оролцуулсан байна.

◆ **АЗИЙН САНГИЙН "B2B_WBC" ТӨСӨЛ**

Төслийн нэр:	B2B_WBC платформыг хэрэгжүүлэх төсөл
Төслийн санхүүжүүлэгч:	Азийн сан
Төсөл хэрэгжүүлэгч:	МҮХАҮТ
Нийт хугацаа:	6 сар
Төсөл эхэлсэн огноо:	2023.12
Төсөл дуусах огноо:	2024.5

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах, бараа бүтээгдэхүүнээ зах зээлд нэвтрүүлэх платформыг хөгжүүлэх төсөл.

◆ **ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ БЛОКЧЭЙН ТЕХНОЛОГИД
СУУРИЛУУЛАХ ТӨСӨЛ**



Төслийн нэр:	Гарал үүслийн цахим гэрчилгээнд зориулсан тархмал бүртгэлийн технологи
Төслийн санхүүжүүлэгч:	Азийн Хөгжлийн банк / АХБ-ны Дижитал сургалтын лаборатори
Төсөл хэрэгжүүлэгч:	МҮХАҮТ
Нийт хугацаа:	8 сар
Төсөл эхэлсэн огноо:	2023.4
Төсөл дуусах огноо:	2023.11

2023 онд АХБ-ны Дижитал сургалтын лаборатори болон Морфиус фирмтэй хамтран ажиллаж гарал үүслийн гэрчилгээг цахимжуулан блокчэйн суурилуулах эхний шатыг амжилттай туршиж дууссан.

◆ **ITC SHETRADES HUB MONGOLIA**



Төслийн нэр:	SheTrades Hub
Төслийн санхүүжүүлэгч:	Олон улсын худалдааны төв
Төсөл хэрэгжүүлэгч:	МҮХАҮТ
Нийт хугацаа:	3 жил
Төсөл эхэлсэн огноо:	2023.06.28
Төсөл дуусах огноо:	2026.06.28

Олон улсын худалдааны төвийн /ITC/ дэргэдэх эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих SheTrades Hub-ийн 14 дахь төв 2023 оны 6 дугаар сарын 30-нд Монгол улсад байгуулагдсан.

Зорилго: SheTrades Hub-аар дамжуулан эмэгтэй бизнес эрхлэгчдийн өөр нэгэн шинэ нэтворкинг платформ бий болж үйл ажиллагаагаа өргөжүүлэх, харилцан туршлага солилцох, дэлхийн худалдааны зах зээлд оролцох шинэ боломжууд бүрдэх юм.

Энэхүү төвөөр дамжуулан Монгол улсын эмэгтэй бизнес эрхлэгчдийн чадавхийг

бэхжүүлэх замаар бизнес хөрөнгө оруулалтын илүү өргөн боломжуудыг нээж, бүс нутгийн гадаад худалдаанд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих, ирээдүйн эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох боломж бүрдэж байна.

SheTrades Hub нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд үүлэн технологиор дамжуулан үйл ажиллагаагаа өргөжүүлэх, ашиг орлого нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох, дэлхийн худалдааны зах зээлд оролцох, ажлын уян хатан зохицуулалт хийх боломжуудыг олгохоос гадна жендерийн тэгш байдлыг хангах эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

СУРГАЛТ

- ◆ Дэлхийн тэргүүлэгч логистикийн компани DHL-тэй хамтран “Power Up Your Business” сэдвээр анхны вебинар сургалтыг 2023 оны 8 дугаар сард зохион байгуулсан.
- ◆ ITC Trade Tools – Олон улсын худалдааны төвийн “Худалдааны хэрэгслийг бизнес хэрхэн ашиглах вэ” сэдэвт дотоод сургалтыг сургалтыг зохион байгуулсан.

АРГА ХЭМЖЭЭ

- ◆ 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр “SheTrades Mongolia Hub: Beyond Your Border” арга хэмжээг зохион байгуулан нийт 150 гаруй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд оролцсон.
- ◆ Швейцар улсын Женев хотод зохион байгуулагдсан ОУХТ-ын дэргэдэх эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих SheTrades Hub-уудын нэгдсэн уулзалтанд оролцсон.
- ◆ “Ambiente 2024” гар урлалын бараа бүтээгдэхүүний үзэсгэлэнд шалгуур ханган сонгогдсон аж ахуй нэгж байгууллагыг үнэ төлбөргүй оролцох боломжийг бий болгосон.
- ◆ Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Хөрөнгө Оруулалтын чуулган арга хэмжээнд SheTrades Hub Mongolia төслийг танилцуулсан.

ГАРЫН АВЛАГА

- ◆ “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд зориулсан экспортын гарын авлага” нь нийт 17 бүлгээс бүрдэх бөгөөд экспортын тухай ойлголтоос эхлэн экспортлох хүртэлх бүх шатны мэдээ мэдээлэл, зөвлөмжүүд багтсан юм.

◆ **МОНГОЛ УЛС ДАХЬ ОЛОН УЛСЫН ХУДАЛДААГ ДЭМЖИХ
ТӨСӨЛ /ITDM/**


Төслийн нэр:	Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх
Төслийн санхүүжүүлэгч:	Азийн сан
Төсөл хэрэгжүүлэгч:	МҮХАҮТ, Бизнес Академи

Нийт хугацаа:	1 жил
Төсөл эхэлсэн огноо:	2022.10.12
Төсөл дуусах огноо:	2023.10.12

Монгол Улс дахь олон улсын худалдааг дэмжих төсөл /ITDM/ нь Европын холбоо болон бүс нутгийн зах зээлд Монголын жижиг дунд үйлдвэрлэлийн худалдааны үр ашгийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тогтвортой, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээнд онцгой анхаарч, Монгол Улсын гадаад худалдааны эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, олон улсын шаардлагад нийцсэн, нэмүү өртөг шингэсэн, уул уурхайн бус салбарын экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготой" юм.

◆ ЗАМ ДАГУУХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогод тусгагдсаны дагуу Аялал жуулчлалын гол чиглэл дагуу 200-250 км тутамд тогтоосон байршлуудад стандартын шаардлага хангасан үйлчилгээний цогцолбор бүхий түр буудаллах цэгүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж буй төслийн хамтран хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.



Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах гэрээг 10 байгууллагатай үзэглэсэн байна. Улсын хэмжээнд батлагдсан нийт 50 байршлаас МҮХАҮТ нь төсөл эхэлснээс хойш 26 байршилд ААН-үүдтэй гэрээ байгуулсан.

Дорнод аймгийн төвд автобуудал, үйлчилгээний цогцолбор

Дорноговь аймгийн Замын-Үүд суманд түр буудаллах цэг, ТИР карней бүхий тээврийн хэрэгслийн зогсоол, үйлчилгээний цогцолбор

Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд автобуудал, үйлчилгээний цогцолбор

◆ ОРГАНИК МОНГОЛ ХӨТӨЛБӨР



2023 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр Органик Монгол Хөтөлбөрийн ТУЗ-ийн хурлыг зохион байгуулан, 2022 оны үйл ажиллагааны тайлан болон 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлуулав.

2023 онд газар тариалангийн бүс нутаг болох Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудад дахин хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийт 10 зээлийн хүсэлт ирсэнээс 5 төсөлд 100 сая төгрөгийн зээл олгосон.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 210 гаруй төслийг санхүүжүүлээд байна.

Зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүд болон хувь хүмүүсийг Намрын ногоон өдрүүд болон Улаанбаатар түншлэл, Орон нутгийн намрын үзэсгэлэнд оролцуулж дэмжин ажилладаг.

МҮХАҮТ нь цаашид хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, 21 аймагт байгалийн нөөцийн хэмнэлттэй, алдагдал хаягдал багатай үйлдвэрлэлийн төслүүдийг дэмжих боломжийг судлан ажиллаж байна.



◆ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

ILO - Олон улсын Хөдөлмөрийн байгууллага

/Албан бус эдийн засгийг албажуулах төсөлд судалгаа хийх/

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага

/Эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх, чадавхижуулах төсөл/

EBRD- Trade Mongolia project

/www.trademongolia.mn веб сайтыг хөгжүүлэх төсөл/




ТАНХИМЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль, МҮХАҮТ-ын дүрэмд заасны дагуу гадаад худалдааны баримт бичиг олгох, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээ, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд, нөхцөл байдлын гэрчилгээ олгох, арбитрын үйлчилгээ үзүүлдэг.


◆ ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

МҮХАҮТ нь экспортын барааны гарал үүслийг гэрчлэх бүрэн эрхийнхээ хүрээнд иргэн, аж ахуйн нэгжүүдэд гарал үүслийн гэрчилгээг тогтмол олгож байгаа бөгөөд 2023 онд "Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын гарал үүслийн гэрчилгээний цахим систем"-ийг хэрэгжүүлэх, хоёр улсын нүүрсний экспорт, импорттой холбоотой мэдээлэл солилцох, гадаад худалдааг хөнгөвчлөх, программ хангамжийг нэвтрүүлэх ажлыг хийж байна. Мөн ХХААХҮЯ-аас мах, махан бүтээгдэхүүний "Экспортын нэг цонхны систем"-д гарал үүслийн гэрчилгээг олгож оруулсан бөгөөд цаашдаа 26 бүтээгдэхүүнийг уг системд нэмж оруулахаар хамтран ажиллаж байна.


ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ



2023 ОНД ОЛГОСОН ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭ /төрлөөр/



◆ ОЮУНЫ ӨМЧ




Бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, найдвартай бизнес эрхлэх орчныг бүрдүүлэх чиглэлээр МҮХАҮТ-ын Патент, барааны тэмдэг, газар зүйн заалтын газар нь Монгол Улсын Оюуны Өмчийн Газраас олгосон №01 дугаартай тусгай зөвшөөрлийн хүрээнд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөллийн үйлчилгээ үзүүлж байна.

2023 онд 164 барааны тэмдэг, 7 шинэ бүтээлийн хүсэлтийг аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч зөвлөх үйлчилгээ үзүүлэн, оюуны өмчийн чиглэлээр 5 танхимын сургалт, орон нутагт 5 цахим сургалт, 6 хурал уулзалтыг зохион байгуулж, бизнес эрхлэгчийг мэдээллээр ханган ажилласан.

Мөн Оюуны өмчийн тухай хуулийн 16.4 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан 2 ажилтан Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн шалгалтад тэнцэж тусгай зөвшөөрлийн эрхээ авлаа.

◆ ЭКСПЕРТИЗ

Монгол Улсын ХАҮТ-ын тухай хуулиар олгогдсон экспорт, импортын барааны тоо, чанарын талаар магадлагаа гаргах хөндлөнгийн шалгалт (экспертиз) хийж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нотолгоо (сертификат)-г олгож байна.



МҮХАҮТ-ын Экспертизийн нэгж нь 2020 онд ISO/IEC 17020:2013 (MNS ISO/IEC 17020:2013) стандартын шаардлагыг ханган "А" төрлийн техникийн хяналтын байгууллагаар 2 жилийн хугацаатай итгэмжлэгдэн 2023 оны 1 сарын 31-ний өдөр 4 жилийн хугацаатайгаар сунгагдан итгэмжлэгдсэн. Энэхүү итгэмжлэл нь тодорхойлсон хүрээнд хяналт гүйцэтгэх техникийн чадавхитай бөгөөд МҮХАҮТ нь чанарын менежментийн тогтолцоотой, IAF-ILAC-ISO-ын 2013 оны хамтарсан мэдэгдлийг мөн үндэслэсэн.

Мөн 2021-2023 онд шалгасан автоцистерн, вагонцистернээс гадна гаалийн болон бизнес эрхлэгчдийн агуулах, чингэлэг, Тирийн нийт үйлчилгээний тоог графикаар харуулж 2021-2023 оны харьцуулалт хийхэд 2021 оны Ковидын үед даатгал, хил гаальтай хамтран ажилласан ба 2022 онд шүүхийн экспертизийн үйлчилгээний тоо нэмэгдсэн, 2023 оны 7-р сараас байгалийн гамшгийн хохирлын дүгнэлт нэмэгдсэн.

◆ ГЭНЭТИЙН БУЮУ ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОН ХҮНД НӨХЦӨЛ БАЙДЛЫН ГЭРЧИЛГЭЭ

Сүүлийн жилүүдэд үүссэн Ковид-19 цар тахал болон ОХУ, Украин улсын дайны нөхцөл байдалтай холбоотойгоор гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын тохиолдлууд ихээр бий болж, иргэн аж ахуйн нэгжүүдээс ирүүлэх гэрчилгээ гаргуулах тухай хүсэлтийн тоо эрс нэмэгдсэн. МҮХАҮТ-аас үүссэн нөхцөл байдлыг тодорхойлох, үйл ажиллагаанд учирсан эрсдэлийг шуурхай зохицуулах, гэрээний талуудад гэрчлэх хүсэлт гаргагчийн зорилгыг дэмжих хүрээнд аж ахуйн нэгжүүдэд гэрчилгээ олгох хууль зүйн үндэслэл, нөхцөл шаардлага, холбогдох журмын талаар сургалт, мэдээллийг өгч, хүсэлтийг тогтоосон хугацаанд шийдвэрлэн зохих хариуг өгч ажиллаж байна.






СУРГАЛТ



Гишүүн байгууллагууд болон бизнес эрхлэгчдэд зах зээлээ өргөжүүлэх, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, мэдлэг мэдээллээр хангах зорилгоор урт болон богино хугацааны сургалт, албан байгууллага дээрх захиалгат сургалтуудыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж байна.


◆ АТА КАРНЕЙ

2003 онд Истанбулын конвенцын гэрээгээр АТА Карней буюу гаалийн татвараас хөнгөлөх гэрчилгээг ашиглахаар 70 гаруй улс орнууд нэгдэн нийлж байсан бол одоогоор Дэлхийн ихэнх хөгжингүй орнууд болох 87 улс АТА Карней гэрчилгээг ашиглаж, олгож цар хүрээний хувьд улам өсөн нэмэгдсээр байна.



Монгол улсын хувьд 2003 онд МУ-ын Засгийн газрын 145-р тогтоолоор МҮХАҮТ-д АТА Карней гэрчилгээг олгох эрх бүхий байгууллагаар томилж, МУ-ын Гаалийн байгууллагатай хамтран ажиллахыг тусгасан байдаг.

2023 оны хувьд Англи Улс, Тайландын Хант Улс, АНУ, Европын Холбоо, Япон Улс, Их Британи, ОХУ зэрэг улсууд руу нийт 38 АТА Карнейн гэрчилгээг олгосон байна.



◆ ХАРВАРД МЕНЕЖМЕНТОР ХӨТӨЛБӨР



Бизнес Академи, Harvard Business Publishing-тай хамтран албан ёсны эрхтэйгээр Harvard ManageMentor хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Дэлхийд нэртэй менежментийн эксперт, манлайлагчдын хамгийн сүүлийн үеийн чухал санаа, сэтгэлгээ, судалгаа, практикаар батлагдсан энэхүү менежментийн хөтөлбөр нь Өөрийгөө удирдах, Бусдыг удирдах, Бизнесээ удирдах гэсэн үндсэн 3 хэсэгтэй, нийт 41 модультай, 4 сарын хугацаанд үргэлжилдэг, онлайнд суурилсан, сүүлийн 20 гаруй жилд тасралтгүй шинэчлэгдэж байгаа сургалтын цогц платформ юм.



◆ ЭКСПОРТ МЕНЕЖЕР

Олон улсын худалдааны бодлого, эрх зүйн зохицуулалтуудыг өөрийн бизнестээ тохируулан зөв ашиглах, экспортын шинэ зах зээлд нэвтрэх стратеги боловсруулах, зах зээлийн судалгаа хийх, экспортын замын зураглалыг гаргах, баримт бичиг бүрдүүлэх, глобал харилцааны ур чадвар




эээмшүүлэх практикт суурилсан нэг сарын хугацаатай "ЭКСПОРТЫН МЕНЕЖЕР" мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Гадаад худалдааны менежерийн хөтөлбөрийн агуулгаас тодорхой хэсгийг авч, боловсруулалт хийж, экспортын менежерийн 160 цагийн онлайн болон танхимын хөтөлбөрийг боловсруулсан. Уг сургалтыг нийт 2 удаа зохион байгуулан, 19 хүн сургаж төгсгөсөн.

◆ CEO UPDATE ХӨТӨЛБӨР

Компанийн захирлуудад зориулсан CEO сургалтыг шинэчлэн, Гүйцэтгэх захирлуудын суурь чадамжийг хөгжүүлэх, илүү сайн гүйцэтгэлтэй хүчирхэг удирдагч болоход манлайллын ухааны хамгийн сүүлийн үеийн мэдлэг, ойлголтыг богино хугацаанд өгөх замаар захирлуудын тасралтгүй хөгжлийг хангах



CEO MINDSET | СЭТГЭЛГЭЭ | CEO KNOWLEDGE | МЭДЛЭГ | CEO SKILLS | УР ЧАДВАР-ЫГ

тодорхойлох 15 үзүүлэлтийн хүрээнд "ЗАХИРЛЫН СУУРЬ ЧАДАМЖ"-ийг хөгжүүлэх, илүү сайн гүйцэтгэл, манлайлалтай хүчирхэг удирдагч болоход чиглүүлэх "CEO UPDATE" хөтөлбөрийг боловсруулан 2 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулсан.

◆ MANAGER DEVELOPMENT BOOTCAMP ХӨТӨЛБӨР



Манлайллын ур чадвараа ахиулан, чадварлаг мэргэжилтнээс урам зоригтой манлайлагч руу шилжих боломжийг олгох энэхүү хоёр өдрийн BOOTCAMP хөтөлбөр нь менежерт зайлшгүй шаардлагатай дараах долоон модуль сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан.

- ◆ Менежерийн үндсэн үүрэг
- ◆ Менежер манлайллын ялгаа
- ◆ Үр дүнтэй харилцаа
- ◆ Багийн динамик воркшоп
- ◆ Коучинг
- ◆ LEAN менежментийг хэрэгжүүлэх, процессыг сайжруулах
- ◆ Шийдвэр гаргах, зөрчил маргааныг шийдэх арга барил

Дунд түвшний удирдлагын хөгжлийн хөтөлбөр нь насанд хүрэгчдийн сурах арга барилд тохируулж олон улсын стандарт сургалтын хөтөлбөрүүдэд суурилсан ба бүх талаас туршлага судлах, бодит кейс ажиллах, дүрд тоглох, синдикат хэлэлцүүлэг, ур чадвар тодорхойлох тест үнэлгээ, багийн ажил зэрэг суралцах цогц арга барилыг ашигласнаараа онцлогтой юм.



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТР



Монголын Олон Улсын Арбитр нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах, арбитрын журмаар хэрэг хянан шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасан иргэдэд тасралтгүй, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТРЫН БҮРЭЛДЭХҮҮН

МҮХАҮТ-ын дэргэдэх
Монголын Олон Улсын
арбитрчид

115

80 Монголын
Арбитрч


35 Олон улсын
Арбитрч




БИЗНЕСИЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

2023 онд нийт 185 нэхэмжлэл шинээр хүлээн авч, 141 маргааныг шийдвэрлэсэн юм. Үүнээс олон улсын хэргийн тоо 23.


ХҮЛЭЭН АВСАН
ХЭРГИЙН ТОО



ШИЙДВЭРЛЭСЭН
ХЭРГИЙН ТОО



ОЛОН УЛСЫН ХЭРГИЙН ТОО



МОУА нь иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад 443 лавлагаа, тодорхойлолт гарган үйлчилгээ үзүүлсэн байна.

ГАДААД ХАРИЛЦАА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА



- ◆ Тайландын Арбитрын Төв /THAC/-тэй хамтын ажиллагааны санамж бичиг
- ◆ БНСУ-ын Хандоны олон улсын хууль зүйн сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг
- ◆ Хятадын олон улсын эдийн засаг, худалдааны арбитрын комисс /CIETAC/-той хамтын ажиллагааны санамж бичиг
- ◆ Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)
- ◆ Шихихутуг Их Сургуультай хамтран ажиллах гэрээ

АРБИТРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАНИУЛАХ БОЛОН АРБИТРЧИЙГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ



Монголын Олон Улсын Арбитраас арбитрын байгууллагын үйл ажиллагаа, давуу тал, онцлогийн талаар танин мэдүүлэх, мэдээлэл өгөх сургалтыг аж ахуйн нэгжүүдэд тогтмол зохион байгуулсан.

МОУА-нь Америкийн Нэгдсэн Улсын Худалдааны яамны санхүүжилтээр хэрэгждэг "Арилжааны эрх зүйн хөгжлийн хөтөлбөр /Commercial Law Development

Program/-тэй шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр хамтарч ажиллахаар тохиролцсоны дагуу МОУА-ын арбитрчид, ажлын албаны мэргэжилтнүүд болон нарийн бичгийн дарга нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хамтарсан сургалтыг амжилттай зохион байгуулсан.

"MOCK TRIAL 2023" АРБИТРЫН МЭТГЭЛЦЭЭНИЙ ТЭМЦЭЭН

Монголын Олон Улсын Арбитраас анх удаа санаачлан зохион байгуулсан "Mock trial-2023" Арбитрын мэтгэлцээний тэмцээн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр амжилттай болж өндөрлөсөн.

"Mock trial-2023" Арбитрын мэтгэлцээний тэмцээнд

- | I байрт | II байрт | III байрт |
|----------------------------------|---|---|
| Шихихутуг Их сургуулийн 2-р баг; | Санхүү Эдийн Засгийн Их сургуулийн 1-р баг; | Монгол Улсын Их сургуулийн 1-р баг тус тус шалгарсан. |

Энэ удаагийн тэмцээнд хууль зүйн 7 сургуулийн 12 баг оролцсон бөгөөд цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулна. Арбитрын мэтгэлцээн нь хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудад хэрэг, маргаан дээр хэргийн оролцогчийн байр сууринаас оролцох, маргааныг шүүхийн бус журмаар хянан шийдвэрлэх практик судалгааг өргөжүүлэх, хөгжүүлэх, эрх зүйн боловсролын хөгжлийг дэмжихэд чиглэсэн бөгөөд Мэтгэлцээний дүрэмд багуудын саналыг тусгасан болно.



◆ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН




МОУА-аас зохион байгуулж буй “Арбитраар маргаан шийдвэрлэх нь” болон “Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх нь” сэдвээр зохион байгуулсан эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан амжилттай зохион байгуулагдсан.

Уралдаанд хууль зүйн салбарын эрдэмтэн, судлаачид болон Монгол Улсын их сургуулийн Хуулийн зүйн

сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Шихихутуг их сургууль, Япон Улсын Нагояагийн их сургуулийн оюутнууд оролцсон нийт 17 илтгэл хүлээн авсан бөгөөд илтгэлүүдийг МОУА-ын арбитрчид үнэлэн шилдэг 10 илтгэлийг шалгаруулсан бөгөөд 2-р шатны шалгаруулалтыг 2023 оны 12 дугаар сарын 6-ны өдөр МҮХАҮТ-ын хурлын танхимд зохион байгуулсан.

◆ “АРБИТРЫН ПОДКАСТ” НЭВТРҮҮЛЭГ




“Арбитрын подкаст”-ын гурав дахь дугаараар Япон Улсын Нагояагийн их сургуулийн докторант М.Мөнхнаран оролцож зүүн өмнөд азийн орнууд болон Монгол Улсад арбитр хэрхэн үүссэн талаар гадаад орны судлаачдын өнцөг, арбитрчид хэрэг хянан шийдвэрлэхдээ юуг анхаарах, хэрэгт оролцогч талууд арбитрч сонгохдоо юуг анхаарах, яаралтай арбитрч гэж хэн болох талаар ярилцсан.

“Арбитрын подкаст”-ын дөрөв дэх дугаар МОУА-ын арбитрч, өмгөөллийн “Легал линк Си Би Эй” ХХН-ийн өмгөөлөгч Б.Батсэлэнгэ оролцсон.

ТАНХИМЫН ДОТООДОД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ


◆ ХҮНИЙ НӨӨЦ



МҮХАҮТ нь 2023 онд батлагдсан нийт 111 орон тооноос идэвхтэй 90 гаруй ажилтан ажиллаж, үйл ажиллагаа явуулж байна. Үүнийг графикаар харуулбал:

◆ СУРГАЛТ

2023 онд цахим болон танхим хосолсон нийт 13 сургалтад ажилтнуудыг хамруулсан байна. Дотоод сургалтанд нийт давхардсан тоогоор 150 гаруй ажилтныг, ажлын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн БНХАУ болон Япон улсуудад 8 ажилтныг дунд болон богино хугацааны сургалтад хамруулсан.



◆ ИДЭВХЖҮҮЛЭЛТ




МҮХАҮТ болон Салбар танхимуудын ажилтнууд СПОРТ ӨДӨРЛӨГ-2023 /2023 оны 3 дугаар сарын 24-25-ны өдөр/

◆ CHAMBER BREAKFAST УУЛЗАЛТ



◆ ХҮҮХДИЙН БАЯР / ШИНЭ ЖИЛ-2023



МҮХАҮТ-ын нийт ажилчдын 16 наснаас доош бүх бяцхан хүүхдүүддээ гарын бэлэг хүргүүлж, мэндчилгээ дэвшүүлсэн.

МҮХАҮТ болон Салбар танхимын ажилчдын ШИНЭ ЖИЛ-ийн баярыг 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан.

◆ МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ




IP суурин утас | IP зөөврийн утас | Дотуур холбоо | Cloud технологи

2023 онд "Юнител ХХК"-ийн системийн шинэчлэлттэй холбоотойгоор танхимын 7727-7070 утасны аппаратад бүрэн шинэчлэлт хийсэн. Энэ ажлын хүрээнд GrandStream DP720, DP722 загварын 19-н ширхэг харилцуур, GrandStream DP750, DP752 загварын 13-н ширхэг утасны

сүлжээ цацагч төхөөрөмж худалдан авч бүх аналог утсыг дижитал системтэй утсаар бүрэн сольж хэрэглээнд нэвтрүүлсэн.

◆ WWW.MONGOLCHAMBER.MN ВЕБ САЙТ

Танхимын албан ёсны цахим хуудас www.mongolchamber.mn веб сайтын судалгааны хэсгийг шинэчлэн хөгжүүлж бизнес эрхлэгч, гишүүддээ онцлох судалгаа, явагдаж байгаа судалгаа, тун удахгүй хийгдэх судалгаа болон судалгаатай холбоотой байгууллагаар, төрлөөр, ангиллаар хайлт, шүүлт хийх байдлаар хурдан шуурхай, эмх цэгцтэй судалгаа олж авах боломжийг бүрдүүлсэн.



◆ TRADEMONGOLIA АППЛИКЕЙШН




Үндэсний хэмжээний аж ахуйн нэгжүүдийн мэдээллийн нэгдсэн сүлжээ www.trademongolia.mn веб сайтад байгууллагууд өөрсдийн брэнд бүтээгдэхүүн, байгууллагын нэр, олонд танигдсан нэршлээр хүссэн дэд домэйнээ үүсгэж ашиглах (forexample.trademongolia.mn), хэрэглэгчид TradeMongolia аппликейшныг татан авч гар утсандаа суулган ашиглах боломжийг бүрдүүлэн PlayStore, AppStore дээр байршуулсан.

◆ MONGOLCHAMBER АППЛИКЕЙШН



Гар утасны аппликейшн бүтээгч компанитай хамтран оролцогч нарын бүртгэлийг хялбар, шуурхай явуулах, санал хураалт ба түүний үр дүнг нэгтгэж харуулах, үүдний хэсэгт хуралд оролцогч нарыг дахин баталгаажуулж хурлын танхимд нэвтрүүлэх, микрофоны өмнө гарч саналаа хэлсэн оролцогчийн мэдээллийг харуулах боломжууд бүхий iOS болон Android гар утсанд зориулсан аппликейшныг хийж МҮХАҮТ-ын XXI-р их хурлын үйл ажиллагаанд ашигласан. XXI-р их

хурлын үеэр ашиглах программтай холбоотойгоор үүрэн холбооны 4 оператортай 147070 дугаарыг шинээр гэрээ байгуулан авч оролцогч нарыг гар утасны дугаараар баталгаажуулан оролцуулсан.



МҮХАҮТ-аас Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулж буй оны онцлох аж ахуй нэгж, байгууллагууд, бизнес эрхлэгчдийг шалгаруулан өргөмжилдөг "ENTREPRENEUR" шалгаруулалтын материалыг дан цаасаар хүлээн авдаг байсныг халж 200 компанийн 220 гаруй материалыг 34 номинацид award.mongolchamber.mn сайтыг ашиглан цахимаар хүлээн авч ажиллалаа.

◆ ЭКСПОРТЫН КАТАЛОГ




МҮХАҮТ-аас Экспортлогчдыг шинэ зах зээлд нэвтрэх, бүтээгдэхүүнээ сурталчлах, зах зээлээ өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, гадаад түнштэй холбох зорилгоор "MONGOLIAN EXPORTERS-2023" цахим каталогийг шинэчлэн гаргасан.

Тус цахим каталогийг танхимын веб сайт, олон улсын бизнес уулзалт, үзэсгэлэн

яармаг, олон улсын элчин сайдын яамд болон худалдааг дэмжих байгууллагууд, МҮХАҮТ-ын төлөөлөгчдөөр дамжуулан өгч дэлхийн зах зээлд Таны бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй сурталчилдаг билээ.

◆ ЭКСПОРТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ НЭГ ЦОНХНЫ ЦАХИМ СИСТЕМ



Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэхтэй холбогдуулан ХХААХҮЯ-наас махны экспорт дээр хэрэгжүүлж буй "Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем"-д МҮХАҮТ нь нэгдэж, программ хөгжүүлэлтийг бүрэн хийж, ашиглалтад оруулснаа Мах, махан бүтээгдэхүүний салбарын ААН-үүдэд танилцуулсан.

"Экспортын гэрчилгээний нэг цонхны цахим систем"-ийг нэвтрүүлснээр Мах, махан бүтээгдэхүүний экспортын гэрчилгээ олгох эрх бүхий төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангах, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, хүнд суртлыг багасгаж мэдээллийн ил тод байдлыг бий болгох, одоо ашиглаж буй системүүдийг холбож мэдээлэл солилцоог сайжруулах, цахим хэлбэрт шилжүүлэх, баримт бичиг бүрдүүлэлтийн шат дамжлагыг бууруулж давхардлыг арилгах, цаг хугацааг хэмнэх, нэгдсэн нэг цонхноос цахимаар мэдээллийг түргэн шуурхай, нэг дор эмх цэгцтэйгээр хүлээн авах боломжтой юм.

◆ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

МҮХАҮТ нь гишүүн байгууллагууд болон харилцагчдадаа үзүүлэх үйлчилгээгээ сайжруулах, ажилтнуудын ажиллах ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор 2023 онд барилга болон ажилтнуудын ажлын хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж шинэчлэх, засвар үйлчилгээнд тодорхой хөрөнгө оруулалтыг хийсэн.


Барилгын гадна талбайн болон дотор талбайд томоохон шинэчлэлүүдийг хийсэн.



/Гадна талбайд цэцгийн мандал, явган шатны урсгал засвар/



/Хурлын 503 болон 407 тоот өрөөнүүдийн ширээ, сандал, смарт дэлгэц шинэчлэлт/



/Цахилгаан шат шинэчлэлт/

Архивын өрөө, хадгаламжийн санг төлөвлөх, өрөө тасалгааг архивын зориулалтаар шинэчлэн бүрэн тохижуулсан.



/Архивын өрөөний шинэчлэлт/

САЛБАР ТАНХИМ



МҮХАҮТ нь
21 аймагт
3389 гишүүдтэйгээр
үйл ажиллагаагаа явуулж байна.

Салбар танхимуудын 2022 оны үйл ажиллагааны тайлангийн хурлыг 2023 оны 3 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд зохион байгуулав. Хуралд 21 аймаг дахь Салбар танхимын дарга, менежерүүд хамрагдан 2022 оны үйл ажиллагааны нэгдсэн тайлангаа бусад танхимуудад болон Үндэсний танхимын удирдлага, газрын дарга нарт танилцуулах, удирдлагуудтай уулзалт хэлэлцүүлэг хийж шилдэг танхим, менежерүүдийг шалгаруулан урамшуулал олголоо. Мөн салбар танхимуудын үйл ажиллагааны дэмжлэгт 2023 онд нийт 446,400,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Бүх салбар танхимын дарга менежерүүдэд заавал суралцах ур чадвар, байгууллагын соёл гэсэн сэдвүүдээр сургалт мэдээлэл өгөв. Мөн Танхимын спортын арга хэмжээнд бүрэн хамрагдсан.

САЛБАР ТАНХИМЫН БАРИЛГЫН ДЭМЖЛЭГ

МҮХАҮТ-ын 2023 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Удирдах зөвлөлийн №3 тоот тогтоолын дагуу Орон нутаг дахь салбар танхимуудын бааз суурь, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Салбар танхимуудыг өөрийн байртай болгоход Үндэсний,



танхимаас тодорхой санхүүжилтийг дэмжлэг болгон олгох шийдвэр гарсны дагуу МҮХАҮТ-ын зүгээс орон нутагт баригдах боломжтой хоёр төрлийн барилгын загвар зураг (эскиз) гаргаж салбар танхимуудад хүргүүлсэн. Мөн эхний ээлжинд Орхон, Өвөрхангай, Булган, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Увс аймгуудыг салбар танхимд 700 сая төгрөгийн санхүүжилт өгсөн.

◆ БҮХ ГИШҮҮДИЙН ХУРАЛ

Завхан аймаг дахь Салбар танхимын бүх гишүүдийн хурлыг зохион байгуулсан. Хуралд нийт 80 гишүүн цугларч 70 хувьтай ирц бүрдэн хурал эхэлсэн. Хурлаар Танхимын дарга Г.Бадамхатан өнгөрсөн 4 жилийн үйл ажиллагааны тайлангаа гишүүддээ хүргэж мэдээлэл хийсэн мөн МҮХАҮТ-ын үйл ажиллагааны танилцуулга мэдээллийг хүргэж ажиллаа. Танхимын даргад 2 хүн шинээр өрсөлдөж Д.Мөнхчимэг /бизнес эрхлэгч/ шинээр томилогдсон.

◆ ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

Монгол-Хятад-Орос гурван улсын худалдаа, үйлдвэрийн танхимуудын 16 дахь удаагийн “Гурван талт чуулган” уулзалтын хүрээнд МҮХАҮТ-ын орон нутгийн салбар танхимууд Орос, Хятадын холбогдох Танхимууд хооронд хамтран ажиллах 50 гаруй санамж бичиг, Монгол, Хятадын 3 компани гэрээ байгуулан, хамтран ажиллахаар болсон.

Монгол Хятадын 4-р экспо, Монгол-Хятад-Оросын худалдааны үзэсгэлэн, Жижиг дунд үйлдвэр, бүтээгдэхүүн үйлчилгээ, Улаанбаатар түншлэл, Намрын ногоон өдрүүд зэрэг үзэсгэлэнгүүдэд орон нутгийн танхимын гишүүд хамрагдсан, мөн Салбар танхимууд Цагаан сар үзэсгэлэнг тогтмол орон нутагтаа зохион байгуулан ажилладаг.

МҮХАҮТ-ын XXI-р Их хуралд салбар танхимаас нийт 400 аж ахуй нэгжүүд оролцсон.

Ховд аймаг дахь Салбар танхимын үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулагдаж Үндэсний танхимаас Удирдлага, мэргэжилтнүүд нийт 13 хүн, Салбар танхимаас 20 хүн оролцлоо.

Булган, Дорнод, Хэнтий, Баянхонгор, Сүхбаатар, Өвөрхангай. Хөвсгөл аймгууд бүсийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтын чуулганыг орон нутагтаа зохион байгуулан ажилласан.

Орон нутгийн бизнес эрхлэгчдийг Улаанбаатар хотын томоохон үйлдвэрүүдтэй танилцуулах, туршлага судлах, Танхимын үйл ажиллагаатай танилцах хөтөлбөртэй ChamberBus хөтөлбөрийг Увс аймгийн бизнес эрхлэгчдийг хамруулан зохион байгуулсан.

◆ СУРГАЛТ МЭДЭЭЛЭЛ

Салбар танхимуудтай хамтран орон нутгийн бизнес эрхлэгчдэд зөвлөгөө мэдээлэл сургалтыг тухай бүр зохион байгуулан ажилласан. Тухайлбал: Салбарын дарга менежерүүдэд МҮХАҮТ-ын нэгдсэн бүртгэлийн систем болон trademongolia.mn сайтын ашиглалтын талаарх мэдээлэл зөвлөгөө, бүртгэл мэдээллийг сайжруулах, Заавал суралцах ур чадвар, байгууллагын соёл, Хүүхэд хамгааллын бодлого, Орон нутгийн онцлог бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Төр хувийн хэвшлийн хэлцэл сургалтуудыг зохион байгуулан ажилласан. Мөн Монголын бизнесийн орчны судалгаа-2518, Бизнесийн итгэлийн индекс судалгаа-347 судалгааг орон нутгийн бизнес эрхлэгчдээс цуглуулан ажилласан.

МҮХАҮТ-ААС ГАРГАСАН МЭДЭГДЭЛ, УРИАЛГА



МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Засгийн Газраас ноолуур, арьс ширний техникийн зохицуулалтын хэрэгжилтийг тодорхой хугацаагаар хойшлуулах, цуцлахаар яригдаж байгаатай холбоотойгоор сүүлийн нэг сар гаруй хугацаанд уг асуудлыг хариуцсан яам, холбогдох мэргэжлийн холбоод, үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд болон мэргэжлийн хүмүүс энэ нь **малын гаралтай түүхий эдийг дотооддоо боловсруулан нэмүү өртгийг бий болгох, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн эсрэг түүхий эдийн экспортыг өөгшүүлэх алхам болно** гэсэн байр суурийг удаа дараа илэрхийлж байна.

Уул уурхайн бус экспортыг хөгжүүлэх, малын гаралтай түүхий эдийг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дэмжих тухай төр засгаас олон жил ярьж ирсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 300 тоот тогтоолоор “Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”, 2022 оны 380 тоот тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг тус тус баталсан бөгөөд Улсын Их Хурлаас 2022 оны 5 дугаар сард Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх 19 дүгээр тогтоолыг гаргасан.

Шинэ сэргэлтийн бодлогын нэг үндсэн зорилт болох аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх тодорхой зорилтуудыг мөн дэвшүүлсэн.

УИХ, Засгийн газрын эдгээр бодлого шийдвэрүүд нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ялангуяа орон нутагт үйлдвэрлэл хөгжих, ажлын байр бий болгох чухал үр нөлөөтэй бөгөөд салбарын бизнес эрхлэгчдэд үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, шинээр үйлдвэр барьж байгуулахад хөрөнгө оруулалт оруулах хүлээлтийг бий болгож, улмаар аж ахуйн нэгжүүд бизнесээ төлөвлөн, бэлтгэл ажлаа эхлүүлж, их хэмжээний хөрөнгө оруулалтыг оруулаад байна.

Иймд Монгол Улсын Засгийн газар бодлогын тогтвортой байдал, гаргасан шийдвэрээ хадгалан, хувийн хэвшилтэй хамтран экспортын боломжит салбаруудын стратегийг гаргах, экспортын санхүүжилтийн ба батлан даалтын тогтолцоог хөгжүүлэх болон экспортын кластеруудыг дэмжин хөгжүүлэх чиглэлээр илүү санаачилга гарган, бодитой дорвитой алхмуудыг хийх нэн шаардлагатай байна.



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН XXI ИХ ХУРЛААС ТӨР, ХУВИЙН ХЭВШИЛД ХАНДАН ГАРГАХ УРИАЛГА

Эдийн засгийн хөгжлийг дэмжих, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, бизнес эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын ээлжит 21 дүгээр их хурлаар эдийн засаг, бизнесийн нөхцөл байдал, бизнес дэх төрийн оролцоо, бизнес эрхлэгчид тулгамдаж байгаа асуудал, нийгэм эдийн засагт бизнес эрхлэгчдийн оруулах хувь нэмрийн талаар санал авч дүгнэн, цаашид төр ба хувийн хэвшил дангаараа болон хамтран шийдвэрлэх асуудлуудыг тодорхойллоо.

МҮХАҮТ-ын их хурлын үеэр явуулсан санал асуулгад оролцсон аж ахуйн нэгжүүдийн 60 хувь нь бизнес дэх төрийн оролцоо дундаас дээш буюу өндөр гэж дүгнэсэн. Төр өөрөө бизнес эрхлэх, хувийн хэвшлийн бүтээгдэхүүн үйлчилгээтэй өрсөлдөх, шаардлагагүй хяналт шалгалт явуулах зэрэг төрийн оролцоо нь бизнест хамгийн сөрөг нөлөөтэй. Харин хууль бодлого гаргах, төрийн худалдан авалт хийх, шаардагдах дэд бүтцээр хангах замаар төр оролцох нь бизнест эерэг нөлөөтэй байна. Ирэх жилүүдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлээ тэлэхэд бизнес эрхлэгчдэд тулгарч буй гол хүндрэлүүд нь санхүүжилт, ажиллах хүч, татварын ачаалал, цар тахлын нөлөө, валютын ханшны өсөлт гэж үзсэн.

Төрөөс бизнесийн орчны тогтвортой байдлыг хадгалах, татварын оновчтой бодлого явуулах, ур чадвартай мэргэжлийн ажиллах хүчнийг бэлтгэх, жижиг дунд үйлдвэрийг дэмжих асуудлуудыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай байгааг санал асуулгад оролцсон бизнес эрхлэгчид илэрхийлсэн. Бизнес эрхлэгчид мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх, ажлын байрыг бий болгох, бизнесийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, авлига хүнд суртлыг бууруулахад хувийн хэвшил илүү хувь нэмрээ оруулах боломжтой гэж үзсэн.

Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, засаглалын институцийг сайжруулах, бизнесийн орчны бодлого хууль эрх зүйг илүү таатай болгох, бодлогын тогтвортой байдлыг хадгалах, эдийн засгийг сэргээхийн тулд дараах асуудлуудыг анхаарч, тодорхой бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх, хамтран ажиллахыг төр засаг ба хувийн хэвшилд хандан уриалж байна. Үүнд:

ТӨР ЗАСАГТ:

1. Бизнес дэх төрийн оролцоог зохистой түвшинд байлгах болон том төслүүдийг эхлүүлэх, хэрэгжүүлэх хууль эрх зүй, бодлогын тогтвортой орчныг бий болгох

2. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, шинэ хөрөнгө оруулалт татахын тулд хөрөнгө оруулалтын шинэ бодлого, стратегийг хувийн хэвшлийн оролцоотой боловсруулах, хөрөнгө оруулалтыг дэмжин сурталчлах, дэмжих
3. Жижиг дунд бизнесийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн сан, зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах, жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжих
4. Эдийн засгийн салбарын өсөлт, гадаад дотоод орчны өөрчлөлт, техник технологи, мэдээллийн технологийн хувьсал өөрчлөлтөд нийцэх ажиллах хүчнийг бэлтгэхэд анхаарч дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын тогтолцоог шинэчлэн өөрчлөх
5. Аж үйлдвэр, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих асуудлыг тогтолцоогоор нь авч үзэх, төрийн байгууллагуудын гаргаж байгаа бодлого, салбар хоорондын зохицуулалт, үйл ажиллагааг уялдуулах
6. Стратегийн ач холбогдол бүхий нефть боловсруулах, зэс хайлуулах ба гангийн үйлдвэр барих болон дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, үйлдвэр шинээр барих, өргөтгөхөд оруулж байгаа хөрөнгө оруулалтыг дэмжих
7. Төр хувийн хэвшлийн үндэсний хэмжээний зөвлөлдөх хороо, түүний доор эдийн засгийн гол салбар бүрт, аймаг бүрт Төр хувийн хэвшлийн зөвлөлдөх бүтцийг бий болгох замаар тогтолцоог бүрдүүлэх, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах
8. Бизнесийнхний хувьд тулгамдсан асуудал болох авлигаас ангид байх, хүнд суртлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх оновчтой тогтолцоог нэвтрүүлэх
9. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн засаглал, удирдлагын тогтолцоонд эрс шинэчлэл хийх, төрийн өмчийг хувьчлах замаар бүтээмж, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх

ХУВИЙН ХЭВШИЛД:

1. Бизнесийн нийтлэг болон тухайлсан салбарын асуудлуудаар хамтран хэлэлцэх, байр сууриа нэгтгэж илэрхийлэх зохистой бүтэц зохион байгуулалтыг дэмжих, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох
2. Бизнест үзүүлж буй төрийн хүнд суртлыг бууруулах, авлигыг зогсоох, улсын төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих олон нийтийн хяналтыг бий болгоход хүчин чармайлт гаргах
3. Салбарын томоохон аж ахуйн нэгжүүд “Sharing economy” буюу хуваалцах эдийн засгийн загвараар дэд бүтэц, тээвэр логистикийн шийдлийг хөгжүүлэх чиглэлийг дэмжих
4. Том аж ахуйн нэгжүүдээс худалдан авалтаар дамжуулан жижиг дунд бизнесийг дэмжих, бараа үйлчилгээгээ чанар стандартын шаардлагад нийцүүлэх чадамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх
5. Хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх, зөв хандлага сэтгэлгээг хэвшүүлэх, зөөлөн ур чадварыг сайжруулахад онцгойлон анхаарах, мэргэжлийн боловсролын хосмог тогтолцоог нэвтрүүлэхэд идэвхтэй оролцох
6. Хувийн хэвшлийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж байгаа хувь нэмрийн талаар эерэг зөв ойлголтыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх
7. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх түүний дотор, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлд аж ахуйн нэгжүүд өөрсдөөс хамаарах арга хэмжээнүүдийг авах, харилцан туршлага солилцох, сайн туршлагыг түгээх

2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр
Улаанбаатар хот